



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГШ НАРЫН ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ДАДЛЫН СУДАЛГАА



UIH.MN
СУДАЛГААНЫ САН



ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГШ НАРЫН ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ДАДЛЫН СУДАЛГАА

Судлаач **Б.БАТХҮҮ**

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

Улаанбаатар хот
2025 он

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН БАГШ НАРЫН ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЛЭГ, ХАНДЛАГА, ДАДЛЫН СУДАЛГАА

Судлаач Б.Батхүү
Жендэрийн зөвлөх, редактор Я.Мөнхчимэг
Дата судлаач Б.Болор

Энэхүү судалгааг Боловсролын төлөө чанга дуугарцгаая!
төслийн санхүүжилтээр хийж, хэвлэв.

EDUCATIONOUTLOUD
advocacy & social accountability



Цаасны хэмжээ: В5

Хэвлэлийн хуудас: 6.5 х.х

Дизайнер: Ж.Халиунцэцэг



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

АГУУЛГА

Өмнөх үг	4
1. Удиртгал.....	4
2. Судалгааны арга зүй.....	7
2.1. Арга зүй, агуулгын хүрээ	7
2.2. Судалгааны түүвэр, дата	8
2.3. Судалгааны хязгаарлагдмал тал.....	10
3. Нөхцөл байдлын шинжилгээ.....	12
3.1. Боловсролын салбар дахь жендэрийн тэгш байдлын өнөөгийн нөхцөл байдал	12
3.2. Боловсролын салбар дахь жендэрийн бодлого, эрх зүйн орчин.....	17
3.3. ЕБС-ийн багш нарын жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг, хандлага, дадал	21
4. Судалгааны үр дүн.....	23
4.1. Багш нарын жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг	23
4.2. Багш нарын жендэрийн тэгш байдалд хандах хандлага	27
4.3. Багш нарын жендэрийн тэгш байдалтай холбоотой дадал	32
4.4. Багш нарын мэдлэг, хандлага, дадлын хамаарлын шинжилгээ	38
5. Дүгнэлт	40
6. Санал, зөвлөмж	43
Ашигласан материалын жагсаалт	46
Хавсралт	48
Хавсралт 1. Мэдлэгийн асуулт, асуултын оноо	48

ӨМНӨХ ҮГ

Боловсрол дахь жендэрийн асуудлыг хөндмөгц “Манай улсад асуудал байхгүй. Охид, эмэгтэйчүүд илүү их боловсролтой болж байгаа” гэдэг үгтэй бид тулдаг. Боловсролын хамран сургалт, сурагчдын ирц, сурлагын амжилтын хувьд хүйсийн ялгаа бага байгаа нь үнэн, гэхдээ энэ нь жендэрийн тэгш байдалд хүрсэн гэсэн үг биш.

Боловсролд хамран сургалт, тэнцвэрт байдлын түвшин сайжирч байгааг жендэрийн тэгш байдлыг хангасан гэж үзэхгүй бөгөөд тэгш эрхийг бодитоор хангах шаардлага хэвээр. Учир нь жендэрийн институцийн хувьд сургуулиуд одоо байгаа жендэрийн тэгш бус байдлыг сөрж өөрчлөхийн оронд хуулбарлан дахин үйлдвэрлэж байгааг бид харж байна. Багшийн зан үйл, суралцагчидтайгаа харилцах байдал, тэдэнд тавьж байгаа хүлээлт, үе тэнгийнхний дунд тогтсон хэм хэмжээ, албан ёсны сургалтын хөтөлбөр болон сургуулийг бүтцийн хувьд хэрхэн зохион байгуулж, удирдаж байгаагаар дамжин хуулбарлагдсаар байна.

Тиймээс бид ЕБС-ийн багш нарын жендэрийн эрх тэгш байдлын талаарх мэдлэг, хандлага, дадлын судалгааг олон улсад хэрэглэгддэг КАР арга зүйг ашиглан хийлээ. Шинээр батлагдсан боловсролын хуулинд “жендэрийг” хүний боловсрол эзэмшихтэй холбоотой ялгаатай хэрэгцээ гэж тусгасан тул багш, боловсролын салбарын ажилтнуудын хувьд зайлшгүй эзэмших ёстой мэдлэг, ур чадвар төдийгүй хандлага, зан үйл болж төлөвшсөн байх ёстой болж байна. Гэтэл судалгаагаар нийт багш нар жендэрийн тэгш байдлын талаар хангалтгүй мэдлэгтэй, жендэрийн хэвшмэл ойлголт-хандлагатай, жендэрийн мэдрэмжтэй дадал бүрэн төлөвшөөгүй байдал илэрлээ. Жендэрийн талаарх сургалтад хамрагдаж байсан багшийн мэдлэг арай илүү, нас залуу багш нарын ойлголт хандлага нааштай, туршлагатай багш нарын эерэг дадал илүү төлөвшсөн зэрэг сонирхолтой үр дүнгүүд гарлаа.

Судалгааны мэдээлэл цуглуулахад дэмжсэн Боловсролын Ерөнхий Газар, Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг, сурагчидтай фокус бүлгийн ярилцлага хийсэн Б.Бэхцэцэг, Ч.Бат-Уянга, Б.Батчимэг нарт талархал илэрхийлье. Боловсролын асуудлаар мэргэшиж буй хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй залуу судлаач Б.Батхүү таны биднийг үргэлж дэмжин, хамтран ажилладагт талархаж байна.

Жендэрийн тэгш байдлыг боловсролд тогтоохын тулд багш нарт мэдлэг, хандлага, зөөлөн ур чадварт суралцах боломжийг нээж, бодит байдлын нарийн төвөгтэй байдлыг ойлгуулах шүүмжлэлт дүн шинжилгээ хийлгэж, суралцагчдын мэдрэмжтэй холбон өөрсдийнх нь хийж байгаа ажил, мөн чанарыг танихад дэмжлэг үзүүлэх явдал юм. Энэ чиглэлээр ИНБ-ууд багш нартай цаашид идэвхтэй хамтран ажиллах болно.

*Д.Тунгалаг
Ерөнхий зохицуулагч*

1. УДИРТГАЛ

Сурч боловсрох эрх нь Үндсэн хууль, олон улсын хүний эрхийн хууль тогтоомжоор баталгаажсан хүний үндсэн эрх бөгөөд бусад эрх, эрх чөлөөг баталгаатай, үр нөлөөтэй хэрэгжүүлэх суурь юм. Ялангуяа, хүүхдүүд, эмэгтэйчүүд, орлого багатай иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, нутгийн уугуул иргэд, хэл болон соёлын цөөнх гэх зэрэг нийгмийн бүлгийн хувьд боловсрол нь нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, хөгжих, ядуурлаас ангижрах үндсэн хэрэгсэл юм. Боловсрол нь эмэгтэйчүүдийг чадавхжуулах, хүүхдийг хүнд хөдөлмөр, хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгөөс хамгаалах, хүний эрх, ардчиллыг дэмжих, байгаль орчныг



хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэдэг.¹ Чанартай боловсрол нь жендэрийн тэгш байдлаас шууд хамаардаг².

Сурагчид өдөрт 5-аас дээш цагийг сургуулийн орчинд өнгөрөөж, нийгэмшиж байдаг тул багш болон бусад сурагчидтай харилцах харилцаагаар дамжуулж жендэрийн ялгаатай байдал, нийгмийн хүлээлт, хэм хэмжээг ойлгож, хүлээн авдаг³. Тиймээс сургуулийн орчин, боловсролын үйл ажиллагаанд жендэрийн тэгш байдлыг хангахад жендэрийн талаарх ойлголттой, жендэрийн мэдрэмжтэй багш нар чухал үүрэг гүйцэтгэнэ⁴. Өөрөөр хэлбэл, багш нарын жендэрийн талаарх хэвшмэл ойлголт, сурган заах арга зүйн арга барил, дадал, харилцаа нь суралцах үйл явц дахь эрэгтэй, эмэгтэй хүйсийн сурагчдад ялгаатай нөлөө үзүүлдэг байна⁵.

Багшлахуй нь “Боловсролын зорилгыг хэрэгжүүлэх багшийн үйл ажиллагаа”, багш мэргэжил нь “Багшлахуйд шаардагдах мэдлэг, чадвар, дадлын цогц” юм. Багш нь хувь хүний төдийгүй, улс орны хөгжлийн хөшүүрэг болж, үүгээр багш мэргэжлийн үнэ цэн тодорхойлогддог. Мөн КОВИД-19-ийн цар тахлын үед дэлхийн болон бүс нутгийн хэмжээнд боловсролд урьд өмнө байгаагүй тасалдал үүсэж, боловсролын хүртээмж, сургалтын үр дүн, сурагчдын оролцоо, тэдний эрүүл мэнд, сайн сайхан байдалд илэрч буй ноцтой өөрчлөлтөөс үүдэн багшийн арга барил, хандлага, мэргэжлийн үр чадварт том өөрчлөлт хийхийг шаардах болсон⁶.

Багш бүр өөрсдийн ажил, үүрэг, хичээлийн сэдэв болон сурагчдынхаа талаар ялгаатай итгэл үнэмшилтэй байдаг⁷. Харин багш нарын жендэрийн талаарх итгэл үнэмшил, хэвшмэл ойлголтууд нь эрэгтэй, эмэгтэй сурагчид өөрсдийнхөө үр чадварыг хэрхэн ойлгож, хүлээн авахад нөлөөлдөг болохыг олон судалгаагаар тогтоосон байдаг⁸. Тухайлбал, Ретелсдорф нарын үзсэнээр (2015)⁹ багш нарын ‘охидын унших чадвар хөвгүүдийнхээс илүү’ гэж үзэх хэвшмэл ойлголт нь хөвгүүдийн өөрийгөө үнэлэх үнэлэмжид нь сөргөөр нөлөөлдөг гэжээ.

Монгол улсын хувьд багш нарын жендэрийн итгэл үнэмшил, хандлага сурагчдад хэрхэн нөлөөлж буй талаарх судалгаа хангалтгүй хэвээр байна. Олон нийтэд нээлттэй байршсан цөөн судалгааны нэг нь Д.Амартүвшин нарын 2023

- 1 Р.Очирбал “Сурч боловсрох эрхийн зарим асуудал”, Боловсролын тухай багц хуулийн төсөл, санал (эмхэтгэл), МУИС Үндсэн хуулийн эрхзүйн хүрээлэн, 2022 он
- 2 Sheila Aikman and Elaine Unterhalter, eds., *Practising Gender Equality in Education: Programme Insights* (Oxfam, 2007).2007
- 3 Pedrajas, Raquel P and Jalandoni, Nove D., “Promoting Gender Equality in the Classroom: Teachers’ Challenges and Strategies,” *Journal for Educators, Teachers and Trainers* 14, no. 3 (2023), <https://doi.org/10.47750/jett.2023.14.03.048>.
- 4 Tuba Acar-Erdol et al., “Gender Equality Perceptions of Preservice Teachers: Are They Ready to Teach It?,” *Social Psychology of Education* 25, no. 4 (2022): 793–818, <https://doi.org/10.1007/s11218-022-09712-8>.
- 5 Marlene Kollmayer et al., “REFLECT – A Teacher Training Program to Promote Gender Equality in Schools,” *Frontiers in Education* 5 (July 2020): 136, <https://doi.org/10.3389/educ.2020.00136>; Pedrajas, Raquel P and Jalandoni, Nove D., “Promoting Gender Equality in the Classroom.”
- 6 У.Туяа et al., “Хувьсаж Буй Боловсрол” Үндэсний Хэлэлцүүлэг (БШУЯ & БСҮХ, 2022).
- 7 Jana Lindner et al., “Toward Gender Equality in Education—Teachers’ Beliefs about Gender and Math,” *Education Sciences* 12, no. 6 (2022): 373, <https://doi.org/10.3390/educsci12060373>.
- 8 Miriam Nürnberger et al., “Implicit Gender Stereotypes and Essentialist Beliefs Predict Preservice Teachers’ Tracking Recommendations,” *The Journal of Experimental Education* 84, no. 1 (2016): 152–74, <https://doi.org/10.1080/00220973.2015.1027807>; Elizabeth A. Gunderson et al., “The Role of Parents and Teachers in the Development of Gender-Related Math Attitudes,” *Sex Roles* 66, nos. 3–4 (2012): 153–66, <https://doi.org/10.1007/s11199-011-9996-2>; Jan Retelsdorf et al., “Michael Can’t Read! Teachers’ Gender Stereotypes and Boys’ Reading Self-Concept,” *Journal of Educational Psychology* (US) 107, no. 1 (2015): 186–94, <https://doi.org/10.1037/a0037107>.
- 9 Retelsdorf et al., “Michael Can’t Read! Teachers’ Gender Stereotypes and Boys’ Reading Self-Concept.”

онд гүйцэтгэсэн “Сургуулийн орчин дахь жендэрийн хэвшмэл ойлголт сурагчдын мэргэжил сонголтод нөлөөлөх байдал” судалгаа байна. Чанарын арга ашигласан тус судалгаагаар сурагчдын мэргэжил сонголтод багш нарын хандлага хамгийн ихээр нөлөөлж буй бөгөөд багш нарын заах арга барил, хандлага, жендэрийн хэвшмэл ойлголт сурагчдын мэргэжил сонголтод тодорхой нөлөөтэй¹⁰ байгаа нь ажиглагдсан байна. Тухайлбал, багш нар инженерийн чиглэлээрх мэргэжилд хөвгүүдийг илүү дэмжих хандлагатай байгааг дурджээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас¹¹ “Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого (2017-2024)”-ыг боловсруулж, салбарын бүх түвшний ажилтан, албан хаагчдын жендэрийн тэгш байдлыг хангах талаарх мэдлэг, чадавхыг сайжруулах үндсэн зорилтыг дэвшүүлсэн байдаг. Гэвч одоог хүртэл ерөнхий боловсролын сургуулийн багш нарын жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг, ойлголт ямар түвшинд байгаа нь тодорхойгүй байна. Харин 2014 онд Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэнгээс гүйцэтгэсэн “Бага, дунд боловсролын жендэрийн дүн шинжилгээ”-нд багш нарын жендэрийн ойлголт, хандлагыг авч үзсэн байдаг ч мэдлэгийн түвшнийг тодорхойлохоос илүү хандлага талаас нь шинжилсэн байдаг. Тэнд багш нарын дийлэнх хэсэгт хөвгүүд, охидод хэвшмэл ойлголтын үүднээс хандах хандлага ажиглагдаж байгааг¹² онцолжээ.

Цаашид Монгол улсын боловсролын чанарыг сайжруулж, урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдийн биелэлтийг хангахын тулд юун түүрүүнд багш нарын жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг, хандлага, дадлыг тодорхойлох зайлшгүй шаардлагатай. Тиймээс энэхүү судалгаагаар ерөнхий боловсролын сургуулийн багш нарын жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг, хандлага, дадал, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлохыг зорилоо.

Тайлан нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ. Тайлангийн эхний хэсэгт “Судалгааны арга зүй”, датаны талаар тайлбарлах бол дараагийн хэсэгт боловсролын салбар дахь жендэрийн тэгш байдлын “Нөхцөл байдлын шинжилгээ”-ний ерөнхий үр дүн, сэдвийн судлагдсан байдлыг тоймлов. Үүний дараа “Судалгааны үр дүн” хэсэгт багш нарын жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг, хандлага, дадлыг тус бүрд нь болон хоорондын хамаарлын хувьд нь шинжилсэн. Тайлангийн төгсөлд судалгааны “Дүгнэлт” болон судалгааны үр дүнгээс гарсан “Санал, зөвлөмж”-ийг орууллаа.

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

10 Д.Амартүвшин et al., Сургуулийн Орчин Дахь Жендэрийн Хэвшмэл Ойлголт Сурагчдын Мэргэжил Сонголтод Нөлөөлөх Байдал (Улаанбаатар, 2023).

11 2024 онд Боловсролын яам, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам болон өөрчлөгдсөн.

12 НБХСХ, Бага, Дунд Боловсролын Жендэрийн Дүн Шинжилгээ (Швейцарийн Хөгжлийн Агентлаг, 2016).

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

2.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

2.1. Арга зүй, агуулгын хүрээ

Анги танхимд жендэрийн эрх тэгш байдлыг хангахад багш нарын мэдлэг, хандлага, дадал (цаашид KAP гэх) нь нэн чухал. Аливаа бүлгийн зан байдлыг өөрчлөхөд мэдлэг, хандлага, дадал нь чухал холбогдолтой байдаг¹³ тул нийгмийн олон салбарын судалгаанд тоон болон чанарын мэдээлэл дээр үндэслэн KAP загварыг ашигласан байдаг. KAP загварыг ашигласнаар нөхцөл байдлыг тодорхойлох, зөрүүтэй байдлыг тодруулах, цаашдын үйл ажиллагаа болон судалгаанд зориулсан суурь нөхцөл байдлыг илрүүлэх, зан байдал өөрчлөх тодорхой үйл ажиллагаануудыг төлөвлөх боломжтой¹⁴. Энэхүү судалгаанд KAP загварыг дараах агуулгын хүрээнд ашиглав.

- **Мэдлэгийн (knowledge)** бүрэлдэхүүн хэсгээр багш нарын жендэр, жендэрийн тэгш байдал, хэвшмэл ойлголт, жендэрийн мэдрэмжтэй сургалтын арга барил, холбогдох бодлого, хууль тогтоомж, Тогтвортой хөгжлийн зорилгуудын талаарх мэдлэг, ойлголтыг тодруулсан.
- **Хандлагын (attitude)** бүрэлдэхүүн хэсгээр багш нарын жендэрийн тэгш байдал, эрэгтэй эмэгтэй суралцагчдын оролцоо, үүрэг, хариуцлага, жендэрийн мэдрэмжтэй сургалтын арга барилын ач холбогдолтой гэсэн хандлага, хэвшмэл ойлголтуудыг тодруулсан.
- **Дадлын (practices)** бүрэлдэхүүн хэсгээр багш нар анги танхимд жендэрийн хэвшмэл ойлголтыг бэхжүүлж, эрэгтэй эмэгтэй суралцагчдад ялгаатай байдлаар ханддаг эсэх, эсрэгээрээ сургалтын үйл ажиллагаандаа жендэрийн тэгш байдлыг хангаж, жендэрийн мэдрэмжтэй арга барил ашигладаг эсэхийг тодруулсан.

Судалгааны мэдээлэл цуглуулалтад **тоон болон чанарын аргыг хослуулан** ашигласан. Тоон судалгаанд ЕБС-ийн багш нарыг хамруулж, хүн амзүйн мэдээлэл, мэдлэг, хандлага, дадлыг тодруулах хаалттай асуултууд бүхий онлайн асуумжаар мэдээлэл цуглуулав. Харин чанарын судалгаанд ЕБС-ийн багш нар болон ахлах

13 Xuewei Liao et al., "Use of the Knowledge, Attitude, and Practice (KAP) Model to Examine Sustainable Agriculture in Thailand," *Regional Sustainability* 3, no. 1 (2022): 41–52, <https://doi.org/10.1016/j.regsus.2022.03.005>.

14 Médecins Du Monde, "The KAP Survey Model (Knowledge, Attitudes, & Practices)," USAID: Washington, DC, USA, 2011.

ангийн сурагчдыг хамруулж, оролцооны аргад тулгуурласан фокус бүлгийн ярилцлагаар багш нарын жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг, хандлага, дадлын талаар илүү дэлгэрэнгүй, гүнзгий мэдээллийг цуглуулж, тоон мэдээллийг тайлбарлахад ашиглав.

Тоон асуумжаар багш нарын жендэрийн тэгш байдлын талаарх **мэдлэгийг үнэлэхдээ** 15 асуулт бүхий мэдлэг шалгах тестийг боловсруулсан. Тухайн тест дэх асуулт бүр хүндрэлийн түвшнээсээ хамаарч зөв хариулт бүрд 1-3 оноо тооцогдоно. Харин буруу эсвэл “мэдэхгүй” гэсэн хариулт бүр 0 оноотой байхаар тооцов. Мэдлэгийн асуултын нийт оноог тооцоходоо дараах томъёог ашигласан.

$$\text{Нийт оноо} = \sum_{i=1}^k S_i \cdot w_i$$

$k=1, \dots, 20$, S_i -*ith* асуултын оноо, w_i -*ith* асуултын хүндрэлийн түвшин

Харин **хандлага болон дадлыг үнэлэхдээ** 4 онооны Лайкертийн шкалыг ашиглаж, онооны дунджаар тооцов. Олон улсад багш нараас авсан санал бодлын судалгаануудад 4 онооны Лайкертийн шкалын үр дүнг дараах байдлаар тайлбарласан байдаг¹⁵ тул энэхүү судалгаанд мөн хандлага, дадлыг тодорхойлохдоо уг тайлбарыг ашигласан.

Хүснэгт 1. Хандлага, дадлын ангилал

Тайлбар	Оноо	Шкалын интервал
Сөрөг	1	1.00 – 1.99
Саармаг (сул эерэг)	2	2.00 – 2.99
Эерэг	3	3.00 – 4.00

2.2. Судалгааны түүвэр, дата

Тоон судалгааны түүвэр: Тоонд судалгаанд ЕБС-ын багш нарыг хамруулсан. 2024-2025 оны хичээлийн жилд ЕБС-д нийт 37,770 үндсэн багш ажиллаж байгаа ба энэхүү тоо нь уг судалгааны түүврийн эх олонлог болно. Түүврийн хэмжээг $\pm 3.43\%$ -ийн алдаа, 95%-ийн итгэх түвшинтэй байхаар дараах томъёогоор тодорхойлов.

$$n = \frac{(z_{\alpha/2})^2 \cdot p^* \cdot (1 - p^*)}{E^2} = \frac{1.96^2 \cdot 0.5 \cdot (1 - 0.5)}{0.0343^2} = 800$$

¹⁵ Abdurrahman Sahin et al., "Context, Process and Change: The Status of Prospective Teachers' Perceptions of Teaching Process," Essays in Education 23, no. 1 (2008): 3.

Үүнд:

- n – Түүврийн хэмжээ
- z – 95 хувийн ач холбогдлын түвшин дэх z статистикийн тархалтын утга 1.96
- α – Ач холбогдлын түвшин буюу 95% итгэх түвшинд тооцов
- p^* - түлхүүр үзүүлэлтийн хувийн жин. (0.5 байхаар тооцоолов)
- E – Таамаглаж байгаа алдааны хязгаарыг аль болох бага хэмжээтэйгээр авах бөгөөд (бидний тохиолдолд таамаглаж байгаа харьцангуй алдаа .0343 = $\pm 3.43\%$ байхаар сонгосон).

Хувьсагчдын утгыг дээрх байдлаар тодорхойлж, түүврийн хэмжээг тооцон 800 багшийг судалгаанд хамруулахад Монгол улсын хэмжээнд төлөөлөх байдал хангагдана гэж тооцоолсон. Судалгааны мэдээлэл цуглуулалтыг KoboToolbox судалгааны платформ ашиглан, 2024 оны 12 сараас 2025 оны 2 сарыг дуустал цахим хэлбэрээр цуглуулсан. Үүний үр дүнд судалгаанд **нийт 822 багш хамрагдсан болно**. Нийт багш нарын 16.5% нь Улаанбаатар хотын ЕБС-д багшилдаг бол үлдсэн 83.5% нь орон нутгийн ЕБС-д багшилдаг байна. Тоон судалгаанд хамрагдсан 822 багшийн хүн-амзүйн болон бусад шинж байдлыг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан багш нарын хүн амзүйн болон бусад шинж байдал ($n=822$)

Судалгаанд оролцогчдын шинж байдал	Давтамж	Хувь
Нас		
21-29	126	15.3%
30-39	288	35.0%
40-49	298	36.3%
50+	110	13.4%
Хүйс		
Эрэгтэй	121	14.7%
Эмэгтэй	701	85.3%
Боловсролын түвшин		
Бакалавр болон дипломын	527	64.1%
Магистр, доктор	295	35.9%
Багшилдаг сургуулийн байршил		
Улаанбаатар хот	136	16.5%
Аймгийн төв	344	41.8%
Аймгийн төвөөс бусад сум	342	41.6%
Заадаг хичээлийн төрөл		
Бага ангийн багш	255	31.0%
Математик	59	7.2%

Судалгаанд оролцогчдын шинж байдал	Давтамж	Хувь
Монгол хэл, уран зохиол	78	9.5%
Байгалийн ухаан (физик, хими, биологи, газар зүй)	114	13.9%
Түүх, нийгэм	76	9.2%
Гадаад хэл (англи, орос, бусад гадаад хэл)	104	12.7%
Зураг төсөл, зураг технологи, технологи	44	5.4%
Биеийн тамир	51	6.2%
Бусад (Мэдээлэл технологи, Эрүүл мэнд, Хөгжмийн боловсрол, Тусгай хэрэгцээт)	41	5.0%
Багшилж буй хугацаа (жилээр)		
0-3	97	11.8%
4-9	196	23.8%
10-20	310	37.7%
21+	219	26.6%
Таны багш мэргэжлийн зэрэг		
Зэрэггүй	167	20.3%
Заах арга зүйч	318	38.7%
Тэргүүлэх	314	38.2%
Зөвлөх	23	2.8%
Жендэр, жендэрийн тэгш байдлын талаарх сургалтад хамрагдаж байсан эсэх		
Тийм	417	50.7%
Үгүй	405	49.3%

Чанарын судалгааны түүвэр: Судалгааны хүрээнд Улаанбаатар, Орхон, Дархан, Төв, Булган аймагт 5 фокус бүлгийн ярилцлага (ФБЯ) хийсэн бөгөөд 2 нь багш нар, 3 нь ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулагдсан. Сурагчдын ялгаатай туршлага, үзэл бодлыг цуглуулах зорилгоор зөвхөн эмэгтэй сурагчдын дунд, зөвхөн эрэгтэй сурагчдын дунд, холимог сурагчдын зэргээр ялгаатай бүлгүүдийг хамруулан зохион байгуулав.

2.3. Судалгааны хязгаарлагдмал тал

Судалгаа нь дараах хязгаарлагдмал талуудтай. Үүнд:

- Судалгааны үр дүнгүүд нь голчлон багш нараас авсан тоон судалгаанд тулгуурлана. Хэдийгээр багш нарын мэдлэгийг үнэлэхдээ объектив тест боловсруулж, оноогоор үнэлсэн боловч хандлага болон дадлын хэсгийг багш нар өөрсдийн үнэлэмж, сонголтод тулгуурлан бөглөсөн болно. Тиймээс

судалгаанд оролцогчид нийгмийн хүлээлтэд тааруулахын тулд бодит байдлаас өөрөөр буюу өөрсдийн хандлага, дадлыг илүү сайнаар харуулахыг хичээсэн байж болзошгүй.

- Мэдлэг, хандлага, дадлын судалгаа нь багш нарын жендэрийн мэдрэмжтэй байдалд нөлөөлж буй нийгэм, соёл, улс төрийн хүчин зүйлс, шалтгаан, сэтгэл зүйн нарийн мэдрэмж зэргийг тодруулах боломжгүй. Тиймээс судалгааны үр дүнд үндэслэн цаашдын эмпирик судалгаануудыг гүйцэтгэх, шалтгааныг тодруулах, шийдлийг судлах шаардлагатай.
- Энэхүү судалгаа нь нэг удаагийн шинжтэй хийгдсэн судалгаа тул харьцуулах суурь үзүүлэлт байхгүй. Тиймээс багш нарын мэдлэг, хандлага, дадал цаг хугацааны турш хэрхэн өөрчлөгдөж буйг харуулах боломжгүй.
- “Бүх нийт боловсролын төлөө!” Иргэний нийгмийн үндэсний эвслийн гишүүн байгууллагуудын тусламжтайгаар, тэдгээрийн үйл ажиллагаа явуулдаг сум, дүүргүүдээс дийлэнх тоон мэдээллийг цуглуулсан. Тиймээс судалгааны түүвэр нь тодорхой аймаг болон бүсийг төлөөлөх чадваргүй боловч дээр дурдсан итгэх түвшин, алдааны хязгаарт улсын хэмжээнд төлөөлөхүйц үр дүнг харуулна.



UIH.MN
СУДАЛГААНЫ САН

3.

НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Хүний хөгжлийн тайланд дурдсанаар 2022 оны байдлаар Монгол улс Хүний хөгжлийн индекс (ХХИ)-ээр нийт 193 орноос 96-р байранд орсон байна. Харин хүний хөгжлийн суурь үзүүлэлтүүд болох эрүүл мэнд, боловсрол, амьдралын стандартаар хэмжигддэг Жендэрийн хөгжлийн индекс 1.032 буюу ХХИ дэх эрэгтэй, эмэгтэйчүүдийн тэгш байдал дундаас дээгүүр орнуудын тоонд оржээ. Хэдий энэхүү хөгжлийн суурь үзүүлэлтүүд эерэг үр дүнтэй байгаа ч Жендэрийн тэгш бус байдлын индексээр 0.297 буюу 166 орноос 72-т орсон доогуур үзүүлэлттэй байна¹⁶. Тэгвэл тайлангийн энэхүү хэсэгт Монгол улсын боловсролын салбар дахь жендэрийн тэгш байдлын өнөөгийн нөхцөл байдлыг хоёрдогч мэдээллийн эх үүсвэрүүд дээр үндэслэн товч шинжиллээ.

3.1. Боловсролын салбар дахь жендэрийн тэгш байдлын өнөөгийн нөхцөл байдал

Сургуульд хамрагдалтын түвшин (Жендэрийн тэгш байдлын индекс)


Боловсролын хүртээмжийг хэмжих үндсэн үзүүлэлт нь сургуульд хамрагдалтын түвшин билээ. НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, Соёлын байгууллага (ЮНЕСКО)-аас эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн боловсролын хамрагдалтын түвшинд үндэслэн улс орнуудын Жендэрийн тэгш байдлын индекс (Gender Parity Index)-ийг гаргадаг. Ингэхдээ эмэгтэй суралцагчдын боловсролын байгууллагуудад хамрагдалтын хувийг эрэгтэй суралцагчдын хувьд хувааж тооцдог. Индекс 1 байвал боловсрол тэгш хүртээмжтэй, 1-ээс бага байвал эмэгтэйчүүдийн хамрагдалт эрэгтэйчүүдийнхээс бага, эсрэгээрээ 1-ээс их байвал эрэгтэйчүүдийн хамрагдалт эмэгтэйчүүдийнхээс бага байна гэж ойлгоно.

Монгол улсын жендэрийн тэгш байдлын индексийг (суурь болон дунд боловсрол) харахад 2021 оны байдлаар индексийн дүн 1 байжээ. Өөрөөр хэлбэл, эрэгтэй, эмэгтэй сурагчдын сургуульд хамрагдалт ижил түвшинд байна. 2010-аас өмнөх онуудад охидын сургуульд хамрагдалт хөвгүүдийнхээс илүү байсан байна. Харин 2018/2019 оны байдлаар индексийг охид, хөвгүүдийн насаар авч үзэхэд 6-14 насанд хөвгүүдийн сургуульд хамрагдалт охидынхоос бага зэрэг их боловч

16 UN, "Human Development Reports: Mongolia," UNDP Web site, Human Development Reports, accessed August 30, 2025, <https://hdr.undp.org/data-center/specific-country-data>.


15 болон түүнээс дээш насныхны хувьд хөвгүүдийн хамрагдалт мэдэгдэхүйц хэмжээнд буурсан дүр зураг харагдаж байна.

Дүрс 1. Жендэрийн тэгш байдлын индекс (суурь болон дунд боловсрол), оноор



Эх сурвалж: Дэлхийн Банк Групп, ДатаБанк, <https://databank.worldbank.org/source/gender-statistics#>


Дүрс 2. Жендэрийн тэгш байдлын индекс (суурь болон дунд боловсрол), насаар, 2018/2019 он



Эх сурвалж: CSWE. (2019). Монгол улсын боловсролын салбарын жендэрийн дүн шинжилгээ

Харин жендэрийн тэгш байдлын индексийг дээд боловсролын¹⁷ түвшинд авч үзвэл сүүлийн жилүүдэд ойролцоогоор 1.3-1.4 индекстэй байна. Өөрөөр хэлбэл, дунд боловсролд хамрагдаж буй суралцагчдын дунд жендэрийн тэгш байдал хадгалагдаж буй боловч түүнээс дээш боловсролын хувьд эрэгтэйчүүдийн хамрагдалт эмэгтэйчүүдийнхээс харьцангуй бага байна. Эрэгтэйчүүд орлого олох, ажил хийх үндсэн шалтгаанаар дээд боловсрол эзэмших нь бага байгаа боловч эмэгтэйчүүдтэй харьцуулахад сургуульд сурах сонирхолгүй байгаагаа илэрхийлэх нь хоёр дахин их байна¹⁸.

Дүрс 3. Жендэрийн тэгш байдлын индекс (дээд боловсрол), оноор



Эх сурвалж: Дэлхийн Банк Групп, ДатаБанк, <https://databank.worldbank.org/source/gender-statistics#>

Түүнчлэн, дээд боловсрол эзэмшиж буй эрэгтэй, эмэгтэй суралцагчдын эзэмшиж буй мэргэжлийн чиглэл нь ихээхэн ялгаатай буюу эмэгтэйчүүд эрүүл мэнд, боловсрол, нийгмийн ажил эрэгтэйчүүдээс 26%-иар, харин инженерчлэл,

17 Энд 'tertiary education'-ийг авч үзсэн буюу дээд боловсролоос гадна техник, мэргэжлийн боловсролыг хамруулан тооцсон.


18 World Bank, Mongolia Gender Assessment (World Bank, 2024).

мэдээллийн технологи зэрэг STEM чиглэлээр эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 26%-иар илүү суралцаж байна¹⁹. Энэхүү мэргэжил сонголтод багш нарын нөлөө хамгийн их²⁰ учир ерөнхий боловсролын сургуулийн багш нар илүү жендэрийн мэдрэмжтэй, мэдлэг ойлголттой байвал энэхүү ялгаатай байдал эергээр өөрчлөгдөх боломжтой юм.

Сургууль завсардалт

Үндэсний Статистикийн Хорооны мэдээллээс харахад бага ангийн хувьд сургуульд хамрагдаагүй хүүхдийн эзлэх хувь дунд ангитай харьцуулахад харьцангуй бага, мөн эрэгтэй, эмэгтэй хүүхдүүд хооронд төдийлөн ялгаа ажиглагдахгүй байна. Харин дунд ангийн хувьд хөвгүүдийн сургууль завсардалт охидынхоос өндөр байгаа нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, хөвгүүдийн дунд сургууль завсардах эрсдэл өндөр байгаа ба энэ нь ихэвчлэн өрхийн амьжиргааны түвшин доогуур, хөдөлмөр эрхлэх, сурах сонирхолгүй зэрэг шалтгаанаас үүдэлтэй байдаг байна²¹.

Дүрс 4. Сургуульд хамрагдаагүй хүүхдийн эзлэх хувь



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, CONT-1 Сургуульд хамрагдаагүй хүүхдийн эзлэх хувь (1212.mn)

Сургууль завсардаж болзошгүй эрсдэлд байгаа бага боловсролын 965 сурагчийн 67.0 хувь нь эрэгтэй, суурь боловсролын 825 сурагчийн 630 буюу 76%

19 World Bank, Mongolia Gender Assessment.

20 Д.Амартүвшин et al., Сургуулийн Орчин Дахь Жендэрийн Хэвшмэл Ойлголт Сурагчдын Мэргэжил Сонголтод Нөлөөлөх Байдал.

21 World Bank Group, "Gender Analysis in Education Sector of Mongolia : A Focus on Boys Education," Text/HTML, World Bank, accessed August 30, 2025, <https://documents.worldbank.org/en/publication/documents-reports/documentdetail/148861604473066031>.

нь эрэгтэй, бүрэн дунд боловсролын 141 сурагчийн 113 буюу 80.0 хувь нь эрэгтэй байна²². Жендэрийн харьцааг 1 эрэгтэй суралцагчид ногдох эмэгтэй суралцагчдын тоогоор, 2021 оны байдлаар авч үзвэл техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын хүйсийн харьцаа нь 0.7, дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдын хүйсийн харьцаа 1.6 байна²³. Хөвгүүдийн боловсролд бага анхаарч, бүрэн дунд боловсролоос завсардуулан, ур чадвар бага шаардах ажилд эрт оруулах хандлага амьжиргааны түвшин доогуур, ялангуяа, малчин өрхүүдэд түгээмэл байна. Энэ нь манай нийгэм, соёлд нэвт шингэсэн патриархат, жендэрийн хэвшмэл хандлага, хэм хэмжээнээс үүдэлтэй бөгөөд хөвгүүдэд чиглэсэн жендэрийн мэдрэмжтэй, тэдний эрэлт хэрэгцээнд нийцсэн бодлого, үйл ажиллагаа хомс, үлгэрлэн дуурайх аав нар, эрэгтэй багш нарын орон зай дутмаг, үе тэнгийнхний хортой эр жендэрийн дүрийн нөлөөнд автах нь нэмэгдэж боловсролоос хөндийрч байна. Улмаар нийгэм сэтгэлзүйн асуудалтай нүүр тулах, гэмт хэрэг, хорт зуршилд автах үр нөлөөтэй байна²⁴. КОВИД-19 хөл хорионы үед хүүхэд, өсвөр үеийнхний нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбоотой асуудал (жирэмслэлт, үр хөндөлт, БЗХӨ зэрэг) болон гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийллийн тохиолдол нэмэгдсэн нь сургуульд буцаж ирэх, суралцах боломжид нөлөөлсөн.

Сурлагын амжилт

Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-аас зохион байгуулж, 15 настай сурагчдын математик, унших чадвар, байгалийн ухааны чадварыг үнэлдэг PISA үнэлгээнд Монгол улс 2022 онд хамрагдсан. Үнэлгээний үр дүнгээс харахад дээр дурдсан гурван чадварын бүгдэд нь охид хөвгүүдээс илүү амжилттай байсан буюу математикийн хувьд 6, унших чадварын хувьд 25, байгалийн ухааны хувьд 15 оноогоор илүү байв²⁵.

Дүрс 5. PISA үнэлгээний үр дүн, хүйсээр (2022 он)



Эх сурвалж: Боловсролын яам, PISA 2022 Сурлагын амжилтын олон улсын үнэлгээний үр дүнг

22 БШУЯ and БСҮХ, Сургууль Завсардаж Болзошгүй Хүүхдийг Илрүүлэх Судалгааны Тайлан (Улаанбаатар, 2021).

23 БШУЯ and ЮНЕСКО, ТХЗ 4 Хэрэгжилтийн Дунд Хугацааны Тайлан (Улаанбаатар, 2022).

24 Т.Эмүжин, Боловсролоос Хөндийрч Буй Хөвгүүд (Улаанбаатар, 2024).

25 OECD, PISA 2022 National Report: Mongolia (OECD, 2022), [https://cdn.greensoft.mn/uploads/users/2760/files/PDF/MONGOLIA_Report_English_WEB%20\(1\).pdf](https://cdn.greensoft.mn/uploads/users/2760/files/PDF/MONGOLIA_Report_English_WEB%20(1).pdf).

Түүнчлэн, элсэлтийн ерөнхий шалгалтын дүнг хараад үзэхэд ч мөн адил бараг бүх хичээл дээр эмэгтэй шалгуулагчид эрэгтэйчүүдээс өндөр оноо авсан байна. Доорх хүснэгтэд харуулсанчлан зарим онуудад Монголын түүх, Орос хэл, Газар зүй зэрэг цөөн хичээлүүд дээр л эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү оноо авчээ.

Хүснэгт 3. Элсэлтийн ерөнхий шалгалтын дүн (хэмжээст оноо), хүйсээр

Хичээл	Хүйс	2018	2019	2020	2021	2022	2023
Математик	Эрэгтэй	496.7	504	501.1	503	505.6	502.2
	Эмэгтэй	503.5	515.8	513.9	517.9	514.6	511.3
Монгол хэл	Эрэгтэй	470.8	479.7	469.2	470.7	477.4	467
	Эмэгтэй	515.3	524.7	530.4	540.1	531.4	529.1
Нийгмийн ухаан	Эрэгтэй	474.5	485.1	482	481.9	483	481.2
	Эмэгтэй	520.6	527.3	528.5	537.2	530	526.6
Англи хэл	Эрэгтэй	498.5	507.1	498.9	501	504.1	504.9
	Эмэгтэй	501.3	505.8	510	515.1	510.7	506.1
Орос хэл	Эрэгтэй	501.5	587.5	565.7	611.8	654.3	560.7
	Эмэгтэй	554.1	588.4	604.5	661.3	634.8	552.9
Газарзүй	Эрэгтэй	505.4	521	512.2	524.9	530.2	520.6
	Эмэгтэй	492.9	513.1	515.7	526.9	535.3	532.7
Физик	Эрэгтэй	496.6	505.9	500.7	505.8	506.1	500.6
	Эмэгтэй	506.9	522.7	520.6	531.4	523.6	524
Биологи	Эрэгтэй	491.7	517.2	493.8	498.5	501.2	494.9
	Эмэгтэй	502.8	511.5	518.9	522.3	519.2	517.1
Хими	Эрэгтэй	493.4	513.5	497.6	500.4	505.2	506.7
	Эмэгтэй	502.6	507.6	513.7	517.7	513.2	512.9
Монгол Улсын түүх	Эрэгтэй	503	527.5	525.8	533.5	535.9	526.2
	Эмэгтэй	497.5	520.6	522.4	538.1	538.1	524.5

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо, ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТЫН ДҮН (ХЭМЖЭЭСТ ОНОО), хүйсээр (1212.mn)

Тэмдэглэл: Эрэгтэй шалгуулагчдын эмэгтэй шалгуулагчаас илүү амжилт гаргасан оноонуудыг ногоон өнгөөр тэмдэглэв.

Багш нарын жендэрийн харьцаа

Багш нарын жендэр, тэдний сурагчдын амжилтын талаарх ойлголт²⁶, сурагчдын сурлагын амжилтад нөлөөлж²⁷, эрэгтэй, эмэгтэй багш нар ялгаатай арга барилтай²⁸ байх боломжтой. Монгол улсын хувьд ерөнхий боловсролын нийт багш нарын дийлэнх нь эмэгтэй багш байдаг. Тухайлбал, 2023-2024 оны хичээлийн жилд ЕБС-д нийт 36,993 үндсэн багш ажилласны 6,652 буюу 18% нь эрэгтэй, 30,341 буюу 82% нь эмэгтэй байна. Доорх хүснэгтээр 2023-2024 оны хичээлийн жилийн байдлаарх багш нарын хүйсийн харьцааг дэлгэрэнгүй байдлаар харуулав.

Хүснэгт 4. ЕБС-ын багш нарын хүйсийн харьцаа, 2023-2024 оны хичээлийн жил

Багш нарын төрөл	Бага ангийн		Зөвхөн дунд ангийн		Зөвхөн ахлах ангийн		Дунд болон Ахлах ангийн	
	Бүгд	Үүнээс эрэгтэй	Бүгд	Үүнээс эрэгтэй	Бүгд	Үүнээс эрэгтэй	Бүгд	Үүнээс эрэгтэй
Тоо	12324	544	12414	3100	5822	1477	6433	1531
Хувь	100.0%	4.4%	100.0%	25.0%	100.0%	25.4%	100.0%	23.8%

3.2. Боловсролын салбар дахь жендэрийн бодлого, эрх зүйн орчин

Олон улсын гэрээ, конвенцууд

Монгол улс 1946 онд НҮБ-д гишүүнээр элссэнээс хойш хүний эрх, боловсрол, жендэрийн тэгш байдлыг хангахтай холбоотой олон улсын гэрээ, конвенцүүдэд нэгдэж, олон улсын өмнө тодорхой үүрэг, хариуцлагуудыг хүлээх болсон. Тэдгээрийн зарим нь хүн бүр хүйсээс үл хамааран сурч боловсрох эрхтэйг тунхаглаж, жендэрийн тэгш байдлыг хангасан чанартай боловсролыг дэмжих зорилтууд дэвшүүлжээ. Доорх хүснэгтэд Монгол улсын элсэж орсон холбогдох гэрээ, конвенцуудын талаар товч харууллаа.



- 26 Thomas S. Dee, "A Teacher like Me: Does Race, Ethnicity, or Gender Matter?," The American Economic Review 95, no. 2 (2005): 158–65, JSTOR.
- 27 Jieun Lee et al., "Teacher Gender, Student Gender, and Primary School Achievement: Evidence from Ten Francophone African Countries," The Journal of Development Studies 55, no. 4 (2019): 661–79, <https://doi.org/10.1080/00220388.2018.1453604>.
- 28 Amita Chudgar and Vyjayanthi Sankar, "The Relationship between Teacher Gender and Student Achievement: Evidence from Five Indian States," Compare: A Journal of Comparative and International Education 38, no. 5 (2008): 627–42, <https://doi.org/10.1080/03057920802351465>.

Хүснэгт 5. Боловсролын салбарт жендэрийн тэгш байдлыг хангахтай холбоотой олон улсын гэрээ, конвенцууд

Гэрээ, конвенцын нэр	Элсэж орсон он	Холбогдох заалтууд
Хүний эрхийн түгээмэл тунхаглал	1948	26-р зүйлийн 1: Хүн бүр сурч боловсрох эрхтэй. 26-р зүйлийн 2: Боловсрол нь бие хүнийг өв тэгш хөгжүүлэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг улам бүр хүндэтгэдэг болоход чиглэх ёстой.
Боловсролын талаар алагчлахтай тэмцэх тухай конвенц	1960	1-р зүйл: “алагчлах” гэсэн нэр томьёо нь боловсролын талаар эрх тэгш харьцааг устгах буюу зөрчих зорилгоор, эсхүл түүний уршгаар арьс үндэс, арьсны өнгө, хүйс, ... зэрэг шинжээр элдвээр ялгаварлах, онцлох, хязгаарлах буюу давуу тал олгохыг илэрхийлнэ.
Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц	1981	10-р зүйл: Оролцогч улсууд боловсролын салбарт эмэгтэйчүүдийг эрэгтэйчүүдтэй тэгш эрхээр хангахын тулд тэднийг алагчилах үзлийг устгах зохистой бүх арга хэмжээг авна.
Инчеоны үйл ажиллагааны хүрээ	2014	Дэлхийн боловсролын чуулга уулзалтын тунхаглал буюу Инчеоны үйл ажиллагааны хүрээ (Education 2030: Incheon Declaration and Framework for Action)-ий тунхаглал нь бүх нийтийн боловсролыг дэмжин, боловсролоор дамжуулан хүртээмжтэй, эрх тэгш байдлыг бий болгох, үүнийг хэрэгжүүлэхэд улс орны Засгийн Газруудын үүрэг хариуцлага, хяналт шинжилгээг чухалчилсан байдаг.
Тогтвортой хөгжлийн зорилго 2030	2015	Зорилго 4: Чанартай боловсролыг дэмжих <ul style="list-style-type: none"> • 2030 он гэхэд боловсролын байгууллагад суралцагсдын жендэрийн зохистой харьцааг хангаж, ... эмзэг бүлгийн хүүхдүүдэд бүх шатны боловсрол, мэргэжлийн сургалтыг тэгш авах боломжийг бүрдүүлэх • 2030 он гэхэд бүх суралцагчдын тогтвортой хөгжил болон тогтвортой амьдралын хэв маяг, хүний эрх, жендэрийн тэгш байдлын боловсрол эзэмшүүлэх Зорилго 5: Жендэрийн тэгш байдлыг хангах
Хувирган өөрчлөх боловсрол санаачилга	2022	НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн Антонио Гутеришийн ивээл дор зохион байгуулагдах “Хувирган өөрчлөх боловсрол” санаачилгын хүрээнд МУ-ын ЗГдараах амлалтыг авсан байдаг ²⁹ . Үүнд, <ol style="list-style-type: none"> 1. Боловсролын ялгаварлыг арилгаж, суралцагч эрүүл, аюулгүй орчинд суралцах боломжийг нэмэгдүүлэх 2. Багш мэргэжлийг хувирган өөрчлөх 3. Сургалтын хөтөлбөр, агуулга, арга зүйг өөрчлөх 4. Цахим шилжилтээр дамжуулан тэгш хамран сургасан, ижил тэгш чанартай боловсролыг хөгжүүлэх 5. Боловсролын санхүүжилтийн инноваци, шинэ схемийг нэвтрүүлэх

²⁹ Хувьсаж буй боловсрол” Монгол Улсын санаачилгын төсөл “ХУВЬСАЖ БҮЙ БОЛОВСРОЛ” МОНГОЛ УЛСЫН САНААЧИЛГА, 2022 он

Хууль, эрх зүйн орчин

Монгол улсын иргэний сурч боловсрох эрх, үүргийг тодорхойлон баталгаажуулсан, боловсрол дахь жендэрийн тэгш байдлыг хангах хамгийн чухал суурь баримт бичиг нь 1992 онд батлагдсан **Монгол Улсын Үндсэн Хууль** юм (Нямцэвээн, 2009). Үндсэн хуулиар Монгол улсын иргэн сурч боловсрох эрхтэй болохыг баталгаажуулж, хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болохыг заасан байдаг.

2023 онд шинэчлэгдэн батлагдсан **Боловсролын Ерөнхий хуульд** “Монгол Улсын боловсролын зорилго нь хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, насан туршдаа суралцаж, ажиллах, ёс суртахуунтай, сайн зан чанартай иргэнийг төлөвшүүлэхэд оршино” гэж заажээ. Мөн тус хуульд суралцагч “эрүүл, аюулгүй, жендэрийн тэгш байдлыг хангасан орчин, нөхцөлд суралцах” эрхтэй ба багш “суралцагчийн ялгаатай хэрэгцээ³⁰, сурлагын түвшинг харгалзан сургалтыг үр дүнтэй удирдан зохион байгуулах, чиглүүлэх” үүрэгтэй болохыг заасан байна. Үүнээс гадна, хуульд заасны дагуу бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт хүний эрхийн боловсрол, жендэрийн эрх тэгш байдлын агуулгыг заавал тусгаж, боловсролын сургалтын байгууллага өмчийн хэлбэр харгалзахгүй хэрэгжүүлэх ёстой байна.

2011 онд батлагдсан **Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд** соёл, боловсролын салбар дахь жендэрийн эрх тэгш байдлын баталгааг заажээ. Холбогдох баталгаануудаас харвал:

1. 12.1. Эрэгтэй, эмэгтэй хүн сургуулийн өмнөх, бага, дунд, мэргэжлийн болон дээд боловсрол эзэмших, албан ба албан бус сургалтад хамрагдах ба мэргэжил дээшлүүлэх, мэргэших, арга зүйн зөвлөгөө авах, мөн сургалтын тэтгэлэг авах тэгш эрх, тэгш боломжтой байна.
2. 12.2. Боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгчийн ажлын байр, сургалтын орчныг жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгаж, жендэрийн сургалт, гэгээрлийн үйл ажиллагааг төлөвлөгөө, хөтөлбөрийн үндсэн дээр хэрэгжүүлнэ.
3. 12.3. ... жендэрийн эрх тэгш байдлыг хангах ажлын үр дүн нь сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийн үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх шалгуур үзүүлэлтийн нэг байна зэрэг болно.

Мөн 2023 онд батлагдсан Боловсролын ерөнхий хуульд дараах дэвшилттэй заалтууд орж, хэрэгжилтийн шатанд байна. Үүнд,

Боловсрол эзэмшихтэй холбоотой “ялгаатай хэрэгцээ” гэж хүний боловсрол эзэмшихтэй холбоотой хөгжлийн бэрхшээл, онцгой авьяас, хэл, соёл, **жендэр**, нийгэм, эдийн засаг, байршлын ялгаанаас үүдэлтэй хэрэгцээг (3.1.24), Суралцагч нь эрүүл, аюулгүй, **жендэрийн тэгш байдлыг хангасан орчин, нөхцөлд суралцах** эрхтэй (10.1.1), Бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт **хүний эрхийн боловсрол, жендэрийн эрх тэгш байдал** агуулгыг заавал тусгаж, боловсролын

30 Хуульд зааснаар ялгаатай хэрэгцээ гэж хүний боловсрол эзэмшихтэй холбоотой хөгжлийн бэрхшээл, онцгой авьяас, хэл, соёл, жендэр, нийгэм, эдийн засаг, байршлын ялгаанаас үүдэлтэй хэрэгцээг хэлнэ.

сургалтын байгууллага өмчийн хэлбэр харгалзахгүй (14.4.3) хэрэгжүүлнэ хэмээн заажээ.

Эдгээрээс харахад Монгол улс холбогдох хуулиуддаа хүн бүр хүйсээс үл хамааран сурч боловсрох эрхтэйг зааж, салбарын жендэрийн эрх тэгш байдлын баталгааг тодорхойлж, боловсролын салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах суурь зохицуулалтуудыг тусгасан нь сайшаалтай юм.

Бодлогын хүрээ

Монгол Улсын Их Хурал 2020 онд Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг **“Алсын Хараа-2050”**-ийг баталж, “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлнэ” гэх зорилтыг дэвшүүлсэн байдаг. Уг зорилтыг хэрэгжүүлэх эхний үе шатад (2021-2030) “Суралцагчийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг хангасан, бүтээлч, чадварлаг багш, хүний нөөцөөр хангана” гэх хүрэх үр дүнг тодорхойлжээ. Өөрөөр хэлбэл, Монгол улс 2030 он хүртэл суралцагчийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагыг хангасан, нэг талаараа жендэрийн мэдрэмжтэй багш нарыг бэлтгэн, ажиллуулахаар төлөвлөсөн байна.

2020 онд Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаалаар **“Боловсролын салбарын хөгжлийн дунд хугацааны төлөвлөгөө 2021-2030”**-г баталсан байдаг. Уг төлөвлөгөөг боловсруулахдаа “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулсан ба уг төлөвлөгөө хэрэгжсэнээр “Алсын хараа-2050”-ийн I үе шат (2021-2030)-ны “Хүн бүрд чанартай боловсрол эзэмших эрх тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог шинэчлэх” зорилтын хэрэгжилт хангагдсан байна гэж үзжээ. Төлөвлөгөөний салбарын түвшинд тодорхойлсон “Зорилт 1.1 Боловсролын чанар, залгамж холбоо, нийцийг сайжруулах”-д “Боловсролын бүх түвшинд суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй өргөжүүлэх” үйл ажиллагааг төлөвлөсөн байна. Гэвч бага, дунд боловсролын хүрээнд дэвшүүлсэн зорилт, тэдгээрийн үйл ажиллагаануудад шууд утгаараа жендэрийн тэгш байдлыг хангахтай холбоотой зорилт, үйл ажиллагааг тодорхойлоогүй байна. Харин Зорилт 3.2-д “Хөгжлийн онцлогоос үл хамааран суралцагчийн бага, дунд боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдах боломжийг нэмэгдүүлэх” зорилтыг дэвшүүлжээ.

Цаашилбал, 2018 онд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас **“Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого (2017-2024)”**-ыг боловсруулж, нэвтрүүлсэн байна. Тус бодлого нь үндсэн 4 зорилттой ба үүний нэг “Зорилт 2. Салбарын бүх түвшний ажилтан, албан хаагчдын жендэрийн тэгш байдлыг хангах талаарх мэдлэг, чадавхыг сайжруулах” зорилт байна. Эндээс харахад, салбарын хувьд жендэрийн тэгш байдлыг хангахад ажилтнуудын энэ талаарх мэдлэг, чадвар нэн чухал болохыг бодлогын хүрээнд онцлон авч үзжээ. Бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөгөөнд уг зорилтын хүрэх үр дүн доорх байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

1. Салбарын удирдах ажилтнуудын жендэрийн тэгш байдлыг хангах үйл явцыг

манлайлах чадвар, үүрэг хариуцлага дээшилсэн байна.

2. Салбарын мэргэжилтнүүд ажил үүргийнхээ хүрээнд жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг нэвтрүүлэх мэдлэг, ур чадварыг эзэмшсэн байна.
3. Салбарын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх хөтөлбөрүүд жендэрийг агуулгатай болсон байна.

Харин хүрэх үр дүн бүрийн шалгуур үзүүлэлтийг харахад салбарын мэргэжилтний мэдлэг, ур чадварын түвшинг хэмжих тодорхой шалгуур үзүүлэлтүүд бус сургалтанд хамрагдсан ажилтнуудын тоо, жендэрийн агуулгатай хөтөлбөрийн тоо зэрэг бодит чанарыг хэмжих боломжгүй шалгуур үзүүлэлтүүдээр тодорхойлсон байна.

2023 онд Боловсрол, шинжлэх ухааны салбарын жендэрийн бодлого стратеги (2017-2024 он)-ийн дунд хугацааны хэрэгжилтийн үнэлгээг гүйцэтгэжээ. Тус үнэлгээний үр дүнгээс харахад бодлогын хэрэгжүүлэлтийн эхний шатанд боловсролын салбарын бүх шатны удирдлага, багш, ажилтнуудад жендэрийн эрх тэгш байдлын талаарх сургалтын модулиуд хангалттай боловсруулагдаж, тодорхой сургалтуудыг амжилттай зохион байгуулсан ч, сургалтууд цөөн цагийн, ганц удаагийн байсан нь үр нөлөөг бууруулж, мэдээллийг нэгтгээгүйгээс үйл ажиллагааны үр дүнг үнэлэх боломжгүй хэвээр байгаа аж³¹.

3.3 ЕБС-ийн багш нарын жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг, хандлага, дадал

Монголын ЕБС-ийн багш нарын жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг, хандлага, дадлыг үнэлсэн судалгааны ажил тун цөөн байна. Одоогоор хийгдсэн байгаа судалгаанууд голчлон багш нарын хандлага болон дадлыг тодруулсан байгаа ба жендэрийн тэгш байдал гэх ерөнхий утгаар нь бус тодорхой нэг тохиолдол, хүрээгээр хязгаарласан шинжтэй байна.

Нийгмийн бодлого, хөгжлийн судалгааны хүрээлэнгийн 2016 онд гүйцэтгэсэн “Бага, дунд боловсролын жендэрийн дүн шинжилгээ”-нд нийт 492 багш нараас асуулга судалгаа авч, тэдний жендэрийн талаарх ойлголт, хандлагыг судалжээ. Жендэрийн талаарх ойлголтыг тодруулахдаа жендэр гэх ойлголтыг хэрхэн ойлгож буй болон Жендэрийн тэгш байдлын тухай хуулийг мэддэг эсэхээр үнэлсэн байна. Харин хандлагыг тодруулахдаа гэр бүл дэх эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн үүрэг болон охид, хөвгүүдийн хэв шинжийн талаар ямар хандлагатайг шинжилжээ. Судалгаанд хамрагдсан нийт багш нарын 60 орчим хувь нь охид, хөвгүүдийн талаарх хэвшмэл ойлголтуудтай санал нийлж байгаа ба 3.9% нь л жендэр гэх ойлголтыг зөв ойлгосон нь харагджээ. Хэдий энэхүү судалгаа нь багш нарын ойлголт, хандлагыг тодруулахыг зорьсон боловч томоохон судалгааны нэг жижиг хэсэг болгож, хэт цөөн асуултаар холбогдох үр дүнг гаргасан тул багш нарын мэдлэг, хандлагыг бүрэн илэрхийлэх хангалттай үр дүн агуулаагүй байна.

31 А.Солонго et al., Боловсрол, Шинжлэх Ухааны Салбарын Жендэрийн Бодлого Стратеги (2017-2024 Он) Дунд Хугацааны Хэрэгжилтийн Үнэлгээ (Улаанбаатар, 2023).

Г.Доржжанцан нарын гүйцэтгэсэн “Монголын сургуульд транс сурагч байх нь” судалгаа транс болон хүйсийн хэвшмэл байдалд үл багтах хүүхэд залуусын сургуулийн болон сургуулийн гаднах орчинд өдөр тутмын амьдралдаа амсаж туулж буй амьдралын туршлагыг судлахыг зорьжээ³². Энэхүү судалгаагаар сургуулийн орчинд транс сурагчдад тулгардаг хүндрэл бэрхшээлүүдийг илрүүлсэн ба үүний нэг нь багш нарын сөрөг хандлага байсан байна. Тухайлбал, ганцаарчилсан ярилцлагад оролцсон сурагчдын мэдээлснээр “багш нар транс сурагчдын эсрэг ялгаварлан гадуурхах хандлагатайн дээр үе тэнгийн дээрэлхэлтийг таслан зогсоох бус өөгшүүлэн дэмжих” хандлага ажиглагджээ. Тухайлбал, багш нар транс сурагчдыг үг хэлээр доромжлох, тодорхой хэмжээнд бие махбодын хүчирхийлэл үзүүлэх, цаашлаад бэлгийн дарамт үзүүлэх тохиолдлууд илэрсэн. Уг судалгааны зохиогчид дүгнэлт хэсэгтээ “Хэдийгээр бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжааны тухай сэдэв 9 дүгээр ангийн эрүүл мэндийн боловсролын хичээлийн хөтөлбөрт багтсан боловч багш нар ихэвчлэн энэ сэдвийг алгасах, заасан ч заах аргазүйн хувьд зарим талаар сөрөг, ялгаварлан гадуурхах хандлагатай байсаар байна” хэмээн онцолжээ.

Д.Амартүвшин нарын (2023) гүйцэтгэсэн “Сургуулийн орчин дахь жендэрийн хэвшмэл ойлголт сурагчдын мэргэжил сонголтод нөлөөлөх байдал” чанарын судалгаагаар сурагчдын мэргэжил сонголтод хамгийн их хамаарч байгаа хүчин зүйл нь багшийн хандлага байсан байна³³. Багш нарын дунд охид илүү хүнтэй харилцах мэргэжилд тохирно, хөвгүүд илүү инженер, мэдээллийн технологийн мэргэжилд тохирно гэсэн хэвшмэл ойлголт ажиглагджээ. Гэвч судалгааны зорилго, хүрээнээс шалтгаалж багш нарын жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг, хандлага, дадлыг төдийлөн нарийвчилж судлаагүй ба зөвхөн мэргэжил сонголттой холбон судалсан байна.

Эдгээрээс харахад Монголын ЕБС-ийн багш нарын жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг, хандлага, дадлыг цогц байдлаар судалж, одоогийн мэдлэгийн түвшин, хандлага, дадлын нөхцөл байдлыг тодруулах шаардлагатай байна. Энэ нь цаашид үр дүнтэй бодлого, хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэхэд нэн ач холбогдолтой юм.



32 Г.Доржжанцан et al., Монголын Сургуульд Транс Сурагч Байх Нь (“Бүх нийт боловсролын төлөө” иргэний нийгмийн үндэсний эвсэл, 2023).

33 Д.Амартүвшин et al., Сургуулийн Орчин Дахь Жендэрийн Хэвшмэл Ойлголт Сурагчдын Мэргэжил Сонголтод Нөлөөлөх Байдал.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

4.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

4.1. Багш нарын жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг

Сургуулийн орчин, анги танхимд жендэрийн тэгш байдлыг хангаж, жендэрийн мэдрэмжтэй сургалтын арга барилыг хэвшүүлэхэд ЕБС-ийн багш нарын энэ талаарх мэдлэг нэн чухал. Тиймээс судалгааны хүрээнд багш нарын жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэгийг 15 асуулт бүхий тест ашиглан үнэллээ. Судалгааны үр дүнг боловсруулахдаа асуулт бүрийн хувьд хүндрэлийн түвшнээс нь шалтгаалж 1-3 оноо өгсөн (Асуулт бүрийн хариултын сонголт, зөв хариулт, хүндрэлийн түвшинг Хавсралт 1-ээс харна уу). Тухайлбал, “Жендэр гэж юу вэ?”. “Жендэрийн тэгш байдал гэж юу вэ?” зэрэг жендэрийн талаарх ерөнхий мэдлэг тодруулсан асуултад зөв хариулбал 1 оноо авах бол Боловсролын ерөнхий хууль, Тогтвортой хөгжлийн зорилгуудын талаар асуусан хууль, бодлогын холбогдолтой асуултуудад зөв хариулбал 3 авна. Мөн асуулт бүрийн хариултын хувилбарт “мэдэхгүй” гэсэн сонголт байгаа ба энэ хариултыг сонговол буруу хариулсантай адилаар 0 оноо авах юм. Ийнхүү багш нар бүх асуултад зөв хариулвал 30 оноо авах боломжтой.

Нийт асуултад хэдэн оноо авснаас хамаарч судалгаанд оролцсон багш нарын мэдлэгийн түвшинг гурав хуваан авч үзэхэд³⁴ **нийт багш нарын 57.3% нь мэдлэг багатай** буюу 0-14 оноо, 39.2% нь дунд түвшний мэдлэгтэй буюу 15-22 оноо авсан бол ердөө 3.5% нь л өндөр мэдлэгтэй буюу 23-30 оноо авсан байна.

Хүснэгт 6. Багш нарын мэдлэгийн түвшин (n=822)

Мэдлэгийн түвшин	Оноо	Давтамж	Хувь
Бага	0-14 оноо	471	57.3%
Дунд	15-22 оноо	322	39.2%
Өндөр	23-30 оноо	29	3.5%
Нийт		822	100.0%

34 30 онооны 50% буюу 15 оноо нь мэдлэгийн дундаж босго оноо гэж тооцон мэдлэгийн түвшинг тогтоов.

Харин нийт асуултын хувьд харж үзвэл **судалгаанд оролцсон багш нар 30 онооноос дунджаар 13.2 оноо авсан буюу 100.0%-аас 44.1%-тай зөв хариулсан** байна. Өөрөөр хэлбэл, нийт багш нар **жендэрийн тэгш байдлын талаар хангалтгүй мэдлэгтэй** байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Асуулт бүрээр авч үзвэл багш нарын хамгийн их хувь нь “Сургууль завсардсан болон сургуулийн гадна байгаа хүүхдүүдийн хүйсийн харьцаа хөвгүүд, охидын аль нь илүү их вэ?” (68.3%), “Жендэр гэж юу вэ?” (66.9%), “Боловсролын ерөнхий хуульд зааснаар бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт жендэрийн эрх тэгш байдлын агуулгыг тусгах нь зайлшгүй юу?” (66.9%), “Жендэрийн тэгш байдал гэж юу вэ?” (64.4%), “Боловсролын ерөнхий хуульд зааснаар “суралцагч нь жендэрийн тэгш байдлыг хангасан орчин, нөхцөлд суралцах үндсэн эрхтэй” гэж үнэн үү?” (64.4%) гэсэн асуултуудад зөв хариулсан байна. Эндээс багш нарын талаас илүү хувь нь жендэр, жендэрийн тэгш байдал гэсэн ойлголтууд, мөн Боловсролын ерөнхий хуульд туссан жендэрийн холбогдолтой агуулгуудын талаар мэдлэгтэй байгаа нь харагдаж байна.

Гэтэл эсрэгээрээ багш нарын 70-аас дээш хувь нь жендэрийн үүрэг, жендэрийн ялгаварлан гадуурхалт, Боловсролын ерөнхий хуульд заасан боловсрол эзэмшихтэй холбоотой ялгаатай хэрэгцээ, Тогтвортой хөгжлийн зорилгуудын талаар мэдлэггүй байгаа нь доорх хүснэгтээс харагдана. Жишээлбэл, “Тогтвортой хөгжлийн 17 зорилгын хэд дэх зорилго нь “Жендэрийн тэгш байдлыг хангах” зорилго байдаг вэ?” гэсэн асуултад нийт багш нарын 16.4% нь л зөв хариулсан байна.

Хүснэгт 7. Мэдлэгийн асуулт бүрийн зөв хариултын хувь (n=822)

№	Асуулт	Зөв хариулсан багш нарын хувь
1	Сургууль завсардсан болон сургуулийн гадна байгаа хүүхдүүдийн хүйсийн харьцаа хөвгүүд, охидын аль нь илүү их вэ?	68.3%
2	Жендэр гэж юу вэ?	66.9%
3	Боловсролын ерөнхий хуульд зааснаар бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт жендэрийн эрх тэгш байдлын агуулгыг тусгах нь зайлшгүй юу?	66.9%
4	Жендэрийн тэгш байдал гэж юу вэ?	64.4%
5	Боловсролын ерөнхий хуульд зааснаар “суралцагч нь жендэрийн тэгш байдлыг хангасан орчин, нөхцөлд суралцах үндсэн эрхтэй” гэж үнэн үү?	64.4%
6	Жендэрийн мэдрэмжтэй сургалтын хөтөлбөр гэж юуг хэлэх вэ?	55.5%
7	Дараах тохиолдлуудаас аль нь жендэрийн ялгаварлан гадуурхалтад тооцогдох вэ?	47.0%
8	Монгол улсад жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэхэд төр, олон нийтийн тэнцүү оролцоог хангах гол байгууллага аль нь вэ?	46.6%

№	Асуулт	Зөв хариулсан багш нарын хувь
9	Монгол улсад боловсролын салбарт зориулсан жендэрийн талаар баримтлах бодлого байдаг уу?	40.2%
10	Жендэрийн хэвшмэл үзэл/ойлголт гэж юу вэ?	36.4%
11	Бэлгийн чиг баримжаатай холбоотой дараах өгүүлбэрүүдээс аль нь худал вэ?	32.6%
12	Дараахаас жендэрийн үүргийг зөв илэрхийлж буй өгүүлбэрийг сонгоно уу.	27.5%
13	“Сургуулийн өмнөх боловсролын байгууллага зэрэг байгууллагын ажил, үйлчилгээний онцлогоос хамаарч нэг хүйсийн хүнийг сонгох нь жендэрийн ялгаварлан гадуурхалт мөн” гэж үнэн үү?	24.0%
14	Боловсролын ерөнхий хуульд “суралцагчийн жендэрээс үүдэлтэй хэрэгцээг боловсрол эзэмшихтэй холбоотой ялгаатай хэрэгцээнд хамруулж үздэггүй” гэж үнэн үү?	23.1%
15	Тогтвортой хөгжлийн 17 зорилгын хэд дэх зорилго нь “Жендэрийн тэгш байдлыг хангах” зорилго байдаг вэ?	16.4%
	Дундаж	44.1%

Тэмдэглэл: 50%-аас дээш оролцогч зөв хариулсан бол ногоон, доош оролцогч зөв хариулсан бол улаанаар тэмдэглэв.

Сонирхолтой нь, “Тогтвортой хөгжлийн 17 зорилгын хэд дэх зорилго нь “Жендэрийн тэгш байдлыг хангах” зорилго байдаг вэ?” (59.9%), “Монгол улсад боловсролын салбарт зориулсан жендэрийн талаар баримтлах бодлого байдаг уу?” (46.7%), “Боловсролын ерөнхий хуульд “суралцагчийн жендэрээс үүдэлтэй хэрэгцээг боловсрол эзэмшихтэй холбоотой ялгаатай хэрэгцээнд хамруулж үздэггүй” гэж үнэн үү?” (43.3%) гэсэн асуултуудад багш нар хамгийн их “мэдэхгүй” гэж хариулсан байна. Эндээс харахад **багш нар “Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого (2017-2024)”-ын талаар маш хангалтгүй мэдээлэлтэй байна. Мөн жендэрээс үүдэлтэй хэрэгцээ нь боловсрол эзэмшихтэй холбоотой ялгаатай хэрэгцээ болохыг дийлэнх багш нар мэдэхгүй хэвээр байна.**

Багш нарын мэдлэгийн түвшин тэдний тодорхой шинж байдлуудаас хамаарч ялгаатай байгаа эсэхийг One-way ANOVA буюу Вариацийн шинжилгээ хийж шалгахад багшилж буй хугацаа, мэргэжлийн зэрэг, жендэр, жендэрийн тэгш байдлын талаарх сургалтад хамрагдаж байсан эсэхээс шалтгаалсан статистикийн хувьд ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсан. Тодруулбал, багшилж буй хугацаа, багш мэргэжлийн зэрэг нь нэмэгдэх тусам багш нарын жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг өндөр болж байна. Сонирхолтой нь 50-аас дээш насны, мөн 20-оос дээш жил ажилласан багш нар бусад буюу залуу багш нараас илүү мэдлэгтэй байгаа нь судалгааны үр дүнгээс харагдсан. Мөн жендэр, жендэрийн тэгш байдлын талаарх сургалтад хамрагдаж байсан багш нар хамрагдаж байгаагүй багш нараас өндөр мэдлэгтэй байгаа нь энэ төрлийн сургалтууд багш нарын мэдлэгийг нэмэгдүүлэхэд

үр дүнтэй болох нь харагдаж байна. ФБЯ-д оролцсон дийлэнх сурагчид ч багш нарыг жендэрийн тэгш байдлын талаарх сургалтад идэвхтэй хамруулах, энэ талын мэдлэгийг нь дээшлүүлэх, сурагчдын ялгаатай байдлыг ойлгож, жендэрийн мэдрэмжтэй сургалтын арга барилд суралцах зайлшгүй шаардлагатайг онцолж байв.

Хүснэгт 8. Багш нарын мэдлэгийн дундаж оноо, шинж байдлаар (n=822)

Судалгаанд оролцогчдын шинж байдал	Мэдлэгийн тестийн дундаж оноо	Ач холбогдолтой ялгаа бий эсэх
Нас		
21-29	12.15	Үгүй
30-39	12.51	
40-49	14.06	
50+	14.1	
Хүйс		
Эрэгтэй	12.82	Үгүй
Эмэгтэй	13.3	
Боловсролын түвшин		
Бакалавр болон дипломын	13.13	Үгүй
Магистр, доктор	13.41	
Багшилдаг сургуулийн байршил		
Улаанбаатар хот	12.74	Үгүй
Аймгийн төв	13.9	
Аймгийн төвөөс бусад сум	12.76	
Заадаг хичээлийн төрөл		
Бага ангийн багш	11.67	Үгүй
Математик	13.8	
Монгол хэл, уран зохиол	14.76	
Байгалийн ухаан (физик, хими, биологи, газар зүй)	14.72	
Түүх, нийгэм	15.64	
Гадаад хэл (англи, орос, бусад гадаад хэл)	13.61	
Зураг төсөл, зураг технологи, технологи	13.93	
Биеийн тамир	9.9	
Бусад (Мэдээлэл технологи, Эрүүл мэнд, Хөгжмийн боловсрол, Тусгай хэрэгцээт)	13.1	

Судалгаанд оролцогчдын шинж байдал	Мэдлэгийн тестийн дундаж оноо	Ач холбогдолтой ялгаа бий эсэх
Багшилж буй хугацаа (жилээр)		
0-3	12.73*	Тийм
4-9	11.96*	
10-20	13.25*	
21+	14.58*	
Таны багш мэргэжлийн зэрэг		
Зэрэггүй	12.28***	Тийм
Заах арга зүйч	12.47***	
Тэргүүлэх	14.39***	
Зөвлөх	14.91***	
Жендэр, жендэрийн тэгш байдлын талаарх сургалтад хамрагдаж байсан эсэх		
Тийм	14.67***	Тийм
Үгүй	11.75***	

Тэмдэглэл: Ач холбогдолын түвшин; *** $p \leq 0.001$, ** $p \leq 0.01$, * $p \leq 0.05$; дээд оноо=30, доод оноо=0

Харин хүйс, боловсролын түвшин, багшилдаг сургуулийн байршил, заадаг хичээлийн төрөл зэрэг хүчин зүйлсээс хамаарч мэдлэгийн түвшинд статистикийн ач холбогдол бүхий ялгаа байсангүй. Гэхдээ багш нарын авсан дундаж оноог заадаг хичээлийн төрлөөр нь хараад үзвэл биеийн тамир, бага ангийн багш нарын энэ талын мэдлэг хамгийн муу, түүх, нийгэм, монгол хэл, уран зохиолын багш нарын мэдлэг хамгийн өндөр байгаа нь сонирхол татаж байв.

4.2. Багш нарын жендэрийн тэгш байдалд хандах хандлага

Тайлангийн энэхүү хэсэгт ЕБС-ийн багш нарын жендэрийн тэгш байдалтай холбоотой хандлагыг тодорхойлсон. Үүний тулд хандлага тодорхойлох 15 бодомжийг өгч багш нараас тухайн бодомжтой санал нийлж буй эсэхийг нь 1-4 оноо бүхий Лайкертийн шкалаар тодруулсан. Үүнд, 1-огт санал нийлэхгүй, 2-санал нийлэхгүй, 3-санал нийлнэ, 4-бүрэн санал нийлнэ гэсэн утгыг илэрхийлнэ. Тайлангийн арга зүй хэсэгт дурдсанчлан судалгааны үр дүнг дундаж оноогоор тайлбарлахдаа дараах байдлаар ангилсан.

Тайлбар	Оноо	Шкалын интервал
Сөрөг	1	1.00 – 1.99
Саармаг (сул эерэг)	2	2.00 – 2.99
Эерэг	3	3.00 – 4.00

Судалгааны асуултууд нь хандлагын эерэг болон сөрөг утгатай бодомжуудаас бүрдсэн. Эерэг утгатай бодомжууд нь жендэрийн тэгш байдлыг дэмжих хандлагыг илэрхийлж байгаа бол сөрөг утгатай бодомжууд нь жендэрийн хэвшмэл ойлголт, тэгш бус байдлыг дэмжих хандлагыг илэрхийлнэ. Нийт асуултуудын дундаж оноог тооцохын тулд сөрөг утгатай бодомжуудын оноог утгын хувьд урвуу кодлох замаар нэгэн жигд болгосон. Ингэснээр бүх асуултын оноог дундажлах, хандлагыг тайлбарлах боломжтой болно. Урвуу кодлоход дараах аргыг ашиглав.

$$\text{Хандлагын оноо} = (\text{Хамгийн дээд оноо} + \text{Хамгийн бага оноо}) - \text{Анхны оноо}$$

Дээрх байдлаар хандлагыг тодорхойлоход нийт багш нарын **жендэрийн тэгш байдалд хандах хандлагын дундаж оноо нь 2.8 буюу хүчтэй эерэг эсвэл сөрөг хандлагагүй, саармаг³⁵ буюу сул эерэг байна.**

Бодомж бүрийн хувьд оролцогчдын хариултыг харвал дийлэнх багш нар жендэрийн тэгш байдлыг дэмжих, уламжлалт хандлагыг үгүйсгэх хандлагатай байгаа ч зарим тохиолдолд хэвшмэл ойлголт, уламжлалт хандлага хадгалагдсаар байна. Тухайлбал, нийт багш нарын 90 орчим хувь нь нийгэм дэх тэгш оролцоо, үүрэг хариуцлагын талаарх 1 болон 2 дахь бодомжтой санал нийлж байна. Мөн жендэрийн тэгш байдал нь эрэгтэйчүүдийн эрх хязгаарладаг талаарх сөрөг агуулгатай 9 дэх бодомжтой багш нарын 72.6% нь санал нийлэхгүй байгаа нь жендэрийн тэгш байдал аль нэг хүйсийг үгүйсгэх тухай биш гэдгийг ойлгож буй сайн үзүүлэлт юм.

Гэтэл сурагчдад ялгаатай үүрэг даалгавар өгөх нь буруу, охид хөвгүүд хүйсээс үл хамааран хүссэн хувцасаа өмсөж болно гэсэн агуулга бүхий 3 болон 6 дахь бодомжтой нийт багш нарын харьцангуй бага хувь буюу ердөө 37.6-48.0% нь л санал нийлсэн байна. Түүнчлэн, математик, байгалийн шинжлэх ухаанд хөвгүүд байгалиасаа сайн, нийгэм, хүмүүнлэгийн хичээлд охид илүү сайн гэх 12 болон 13 дахь бодомжтой 37.9-44.5% нь санал нийлж буй нь зарим хэвшмэл ойлголтууд багш нарын дунд хүчтэй хэвээр буйг харуулж байна.

35 Саармаг гэдгийг Монгол хэлний их тайлбар тольд "эерэг, сөрөг буюу аливаа зүйлийн хоёр талын аль алины нь шинжийг агуулсан дундын байдал" гэж тайлбарласан байдаг.

Хүснэгт 10. Багш нарын жендэрийн тэгш байдалд хандах хандлага (n=822)

№	Бодомж	Огт санал нийлэхгүй	Санал нийлэхгүй	Санал нийлнэ	Бүрэн санал нийлнэ
Эерэг утга бүхий бодомжууд					
1	Би эрэгтэй, эмэгтэй хүмүүс нийгэм, соёлын бүхий л харилцаанд тэгш эрхтэй оролцож, хөгжлийн үр шимээс тэгш хүртэх ёстой гэж боддог.	3.9%	6.2%	32.7%	57.2%
2	Би гэрийн ажил хийх, хүүхэд асрах ажилд эхнэр, нөхөр хоёр тэгш эрхтэй байж, ижил үүрэг хариуцлага хүлээх ёстой гэж боддог.	4.0%	7.4%	33.2%	55.4%
3	Багш нар эрэгтэй, эмэгтэй сурагчдын хүйсээс хамаарч ялгаатай үүрэг бүхий даалгавар өгөх нь буруу.	21.4%	30.7%	30.8%	17.2%
4	Хичээл дээрээ багш нар жендэрийн хэвшмэл ойлголтын талаар хэлэлцэж, задлан шинжлэх хэрэгтэй.	7.2%	20.0%	49.3%	23.6%
5	Багш нарын жендэрийн хэвшмэл ойлголт сурагчдын мэргэжил сонголтод нөлөөлж, тэдний хүсэл сонирхолд сөргөөр нөлөөлөх боломжтой.	19.1%	34.9%	35.3%	10.7%
6	Эмэгтэй хүүхэд хүсвэл өмд өмсөх, эрэгтэй хүүхэд ээмэг зүүх, юбка өмсөхийг би хүлээн зөвшөөрнө.	30.4%	32.0%	26.2%	11.4%
7	Боловсролын салбарын бүхий л бодлого, хөтөлбөрүүд жендэрийн тэгш байдлыг чухалчлан авч үзэх шаардлагатай.	7.5%	18.7%	47.7%	26.0%
8	Багш нарт жендэрийн мэдрэмжтэй сургалтын арга зүй, дидактикийн талаар мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах хэрэгтэй.	6.6%	18.7%	48.3%	26.4%
Сөрөг утга бүхий бодомжууд					
9	Жендэрийн тэгш байдлыг хангаснаар эрэгтэйчүүдийн эрх хязгаарлагдаж, эмэгтэйчүүд давуу эрхтэй болно.	41.2%	31.4%	19.7%	7.7%
10	Би эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс илүү удирдах албан тушаал хашихад тохиромжтой гэж итгэдэг.	32.5%	33.7%	25.1%	8.8%

№	Бодомж	Огт санал нийлэхгүй	Санал нийлэхгүй	Санал нийлнэ	Бүрэн санал нийлнэ
11	Сурах бичиг, хичээлийн хэрэглэгдэхүүнд багш, эмч, асрагч зэрэг мэргэжлийг зөвхөн эмэгтэй хүнээр, цэрэг, барилгачин, инженер хүмүүсийг зөвхөн эрэгтэй хүнээр дүрслэн харуулах нь жендэрийн хэвшмэл ойлголтыг бэхжүүлж байгаа хэрэг биш.	20.8%	30.4%	31.0%	17.8%
12	Шинжлэх ухаан, Технологи, Инженерчлэл, Математик (STEM)-ийн хичээлүүд дээр байгалиасаа хөвгүүд охидоос илүү чадварлаг байдаг.	21.2%	34.3%	32.5%	12.0%
13	Нийгэм, хүмүүнлэгийн хичээлүүд дээр байгалиасаа охид хөвгүүдээс илүү сайн суралцдаг.	23.2%	38.8%	29.9%	8.0%
14	Эмэгтэй хүүхэд илүү нямбай, зохион байгуулалт сайтай байдаг учир охидыг ангийн дарга болгох нь илүү үр дүнтэй байдаг.	29.6%	39.7%	22.9%	7.9%
15	Бэлгийн цөөнх сурагчид сургууль дээр тэрийгээ нууж, бусдад үүнийгээ мэдэгдүүлэхгүй байх нь зүйтэй гэж би боддог.	22.6%	34.8%	31.3%	11.3%

Судалгаагаар боловсролын салбарын бодлого, хөтөлбөрт жендэрийн тэгш байдлыг чухалчлах хэрэгтэй эсэх, багш нарыг жендэрийн мэдрэмжтэй сургалтын арга зүй, дидактикийн талаар сургах хэрэгцээтэй эсэхийг (7 болон 8 дахь бодомж) тодруулахад 74 орчим хувь нь санал нийлж байна. Өөрөөр хэлбэл дийлэнх багш нар цаашид энэ чиглэлээр сурах, чадавхаа бэхжүүлэхэд нээлттэй хандлагатай байгаа нь сайшаалтай үр дүн юм.

Багш нарын дунд хийсэн ФБЯ-аар эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийн давуу болон сул талыг багш нар хэрхэн үзэж буйг тодруулахад дийлэнх багш нар **охидыг нягт нямбай, анхаарал төвлөрөх чадвар сайтай, нухацтай** зэргээр тодорхойлж байв. Харин **хөвгүүдийн давуу талыг сэтгэн бодох чадвар сайтай, хурдтай, сэргэлэн, алсыг харах чадвартай** зэргээр тодорхойлох нь түгээмэл байлаа. Эсрэгээрээ охидын сул талыг дүгнэхдээ **эмзэг, сэтгэл хөдлөл ихтэй, өөрийнхөөрөө** гэсэн бол хөвгүүдийг **анхаарал төвлөрөх чадвар сул, тууштай биш, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадвар сул, буруу зүйлд уруу татагдахдаа амархан** зэргээр тодорхойлж байв. Эндээс багш нарын дунд жендэрийн уламжлалт хандлага хэвээр хадгалагдаж буйг харж болох ба багш нар энэхүү тогтсон хандлага дээрээ үндэслэж хүүхдүүдэд хүлээлт тавьж, харилцвал жендэрийн ялгаатай байдлыг бий болгох эрсдэлтэй юм. Тайлангийн дадлын хэсэгт энэхүү хандлагууд багш нарын дадлаар хэрхэн илэрч буйг сурагчидтай хийсэн ФБЯ-ын үр дүнгээр тайлбарлах болно.

Багш нарын хандлага тэдний тодорхой шинж байдлуудаас хамаарч ялгаатай байгаа эсэхийг One-way ANOVA буюу Вариацийн шинжилгээ хийж шалгахад нас, жендэр, жендэрийн тэгш байдлын талаарх сургалтад хамрагдаж байсан эсэхээс шалтгаалсан статистикийн хувьд ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсан. **Хэдий нас, ажилласан жил нэмэгдэх тусам багш нарын жендэрийн талаарх мэдлэг нэмэгдэж байсан ч хандлагын хувьд эсрэгээрээ залуу багш нар илүү эерэг хандлагатай байгаа нь судалгаанаас харагдаж байна.** Мөн жендэр, жендэрийн тэгш байдлын талаарх сургалтад хамрагдаж байсан багш нар хамрагдаж байгаагүй багш нараас илүү эерэг хандлагатай байгаа нь мэдлэгийн үр дүнтэй ижил, энэ төрлийн сургалтын ач холбогдол өндөр болохыг баталж байна.

Хүснэгт 11. Багш нарын хандлагын дундаж оноо, шинж байдлаар (n=822)

Судалгаанд оролцогчдын шинж байдал	Хандлагын дундаж оноо	Ач холбогдолтой ялгаа бий эсэх
Нас		
21-29	2.87*	Тийм
30-39	2.83*	
40-49	2.78*	
50+	2.75*	
Хүйс		
Эрэгтэй	2.74	Үгүй
Эмэгтэй	2.82	
Боловсролын түвшин		
Бакалавр болон дипломын	2.82	Үгүй
Магистр, доктор	2.78	
Багшилдаг сургуулийн байршил		
Улаанбаатар хот	2.82	Үгүй
Аймгийн төв	2.81	
Аймгийн төвөөс бусад сум	2.8	
Заадаг хичээлийн төрөл		
Бага ангийн багш	2.74	Үгүй
Математик	2.84	
Монгол хэл, уран зохиол	2.89	
Байгалийн ухаан (физик, хими, биологи, газар зүй)	2.88	
Түүх, нийгэм	2.93	
Гадаад хэл (англи, орос, бусад гадаад хэл)	2.83	

Судалгаанд оролцогчдын шинж байдал	Хандлагын дундаж оноо	Ач холбогдолтой ялгаа бий эсэх
Зураг төсөл, зураг технологи, технологи	2.74	
Биеийн тамир	2.67	
Бусад (Мэдээлэл технологи, Эрүүл мэнд, Хөгжмийн боловсрол, Тусгай хэрэгцээт)	2.77	
Багшилж буй хугацаа (жилээр)		
0-3	2.86	Үгүй
4-9	2.82	
10-20	2.8	
21+	2.79	
Таны багш мэргэжлийн зэрэг		
Зэрэггүй	2.82	Үгүй
Заах арга зүйч	2.81	
Тэргүүлэх	2.79	
Зөвлөх	2.86	
Жендэр, жендэрийн тэгш байдлын талаарх сургалтад хамрагдаж байсан эсэх		
Тийм	2.83*	Тийм
Үгүй	2.79*	

Тэмдэглэл: Ач холбогдолын түвшин; *** $p \leq 0.001$, ** $p \leq 0.01$, * $p \leq 0.05$; дээд оноо=30, доод оноо=0

Сурагчдын дунд хийсэн ФБЯ-ууд ч мөн дээрх үр дүнг баталж байв. Тухайлбал, сурагчдын мэдээлж буйгаар ахмад, олон жил ажилласан багш нар жендэрийн тэгш байдлын талаар мэдлэгтэй байдаг хэдий ч тэдний хэвшмэл ойлголт, тогтсон зан байдал нь хэвээр хадгалагдаж, залуу багш нартай харьцуулахад жендэрийн мэдрэмжгүй хандлага, үйлдэл гаргах нь илүү байдаг гэжээ.

Харин хүйс, боловсролын түвшин, багшилдаг сургуулийн байршил, багш мэргэжлийн зэрэг, заадаг хичээлийн төрөл зэрэг бусад хүчин зүйлсээс хамаарч багш нарын хандлагад статистикийн ач холбогдол бүхий ялгаа байсангүй. Гэхдээ заадаг хичээлийн хувьд мэдлэгийн хэсэгтэй адилаар биеийн тамирын багш нарын өгсөн оноо хамгийн бага байхад түүх, нийгмийн багш нарын оноо хамгийн өндөр байна.

4.3. Багш нарын жендэрийн тэгш байдалтай холбоотой дадал

Тайлангийн энэ хэсэгт ЕБС-ийн багш нарын жендэрийн тэгш байдалтай холбоотой дадлыг тодорхойлов. Үүний тулд жендэрийн тэгш байдалтай холбоотой 15 тохиолдлыг өгч, тухайн үйлдлийг хэр давтамжтай үйлддэг болохыг 1-4 оноо бүхий Лайкертийн шкалаар тодруулсан. Үүнд, 1-огт үгүй, 2-ганц удаа, 3-хэд хэдэн удаа, 4-олон удаа гэсэн утгыг илэрхийлнэ. Тайлангийн арга зүй хэсэгт дурдсанчлан судалгааны үр дүнг дундаж оноогоор тайлбарлахдаа хандлагын хэсгийн адилаар дараах байдлаар ангилсан.

Хүснэгт 12. Хандлага, дадлын ангилал

Тайлбар	Оноо	Шкалын интервал
Сөрөг	1	1.00 – 1.99
Саармаг (сул эерэг)	2	2.00 – 2.99
Эерэг	3	3.00 – 4.00

Судалгааны асуултууд нь жендэрийн тэгш байдалтай холбоотой эерэг болон сөрөг дадал бүхий үйлдлүүдээс бүрдсэн. Нийт асуултуудын дундаж оноог тооцохын тулд сөрөг дадал бүхий бодомжуудын оноог утгын хувьд урвуу кодлох замаар нэгэн жигд болгосон. Ингэснээр бүх асуултын оноог дундажлах, дадлыг тайлбарлах боломжтой болсон. Урвуу кодлоход дараах аргыг ашиглав.

$$\text{Дадлын оноо} = (\text{Хамгийн дээд оноо} + \text{Хамгийн бага оноо}) - \text{Анхны оноо}$$

Дээрх байдлаар дадлыг тодорхойлоход нийт багш нарын **жендэрийн тэгш байдалтай холбоотой дадлын дундаж оноо нь 2.8 буюу хүчтэй эерэг эсвэл сөрөг хандлагагүй, саармаг буюу сул эерэг байна.**

Багш нарын дадлыг тохиолдол бүрийн хувьд харвал жендэрийн мэдрэмжтэй дадал тодорхой хэмжээнд төлөвшсөн байна. Тухайлбал, нийт багш нарын 76.0% нь сурагчдын идэвх оролцоог тэгш үнэлэх (5 дахь бодомж), 69.6% нь хичээлийн явцад жендэрийн мэдрэмжгүй үг хэллэг хэрэглэхгүй байхыг хичээх (8 дахь бодомж), 64.7% нь ангийн даргыг сонгохдоо эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийг ээлжлэн сонгох (1 дэх бодомж), 62.3% нь жендэрийн ялгаварлан гадуурхалтыг мэдээлэх (6 дахь бодомж) үйлдлийг олон удаа эсвэл хэд хэдэн удаа хийдэг гэж хариулжээ. Гэхдээ багш нарын 30 орчим хувь нь эдгээр үйлдлүүдийг огт хийдэггүй эсвэл ганц удаа хийсэн байгааг зайлшгүй анхаарах шаардлагатай. Мөн жендэрийн мэдрэмжгүй тохиолдлуудад хэрхэн хариулсныг харвал багш нарын 80.9% нь жендэрийн хэвшмэл ойлголт бүхий хэлц үгс хэрэглэх (10 дахь бодомж), 79.0% нь эрэгтэй, эмэгтэй хоёр хүүхэд адилхан сахилгагүйтвэл ялгаатай хандах (14 дэх бодомж), 73.2% нь уламжлалт үүрэгт тохирохгүй сонирхлыг үл дэмжих (11 дэх бодомж) үйлдлүүдийг огт хийдэггүй эсвэл ганц удаа хийсэн байна. Эсрэгээрээ 20 орчим хувь эдгээр үйлдлүүдийг хэд хэдэн удаа эсвэл олон удаа үйлдсэн байгааг дурдах шаардлагатай.

Харин багш нарын сургуулийн орчинд жендэрийн тэгш байдлыг бие даан дэмжих оролдлого хамгийн сул байна. Тодруулбал, багш нарын 67.9% нь сургуулийнхаа бодлого, үйл ажиллагаануудыг илүү жендэрийн мэдрэмжтэй болгох тал дээр санал санаачилга гаргах (4 дэх бодомж), 57.5% нь жендэрийн мэдрэмжтэй сургалтын арга барилын талаар мэдлэгээ дээшлүүлэх (2 дахь бодомж), 55.4% нь бусад багш нартай энэ талаар хэлэлцэх (7 дахь бодомж) үйлдлүүдийг огт хийдэггүй эсвэл ганц удаа хийж байсан гэж хариулжээ. Хэдий хандлагын хэсэгт багш нар жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэгээ дээшлүүлэхэд эерэг хандлагатай байсан ч өөрсдөө хичээл зүтгэл бага гаргадаг болох нь эндээс харагдаж байна.

Хүснэгт 13. Багш нарын жендэрийн тэгш байдалтай холбоотой дадал (n=822)

№	Бодомж	Огт үгүй	Ганц удаа	Хэд хэдэн удаа	Олон удаа
Эерэг утга бүхий бодомжууд					
1	Би ангийн дарга эсвэл аливаа анги доторх бүлгийн даргыг сонгохдоо эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийг ээлжлэн сонгодог (үргэлж нэг хүйсийн хүүхдийг сонгохоос сэргийлж).	21.4%	13.9%	44.4%	20.3%
2	Би жендэрийн тэгш байдал, жендэрийн мэдрэмжтэй сургалтын арга барилын талаар ном сурах бичиг, мэдээлэл хайж, энэ талын мэдлэгээ дээшлүүлдэг.	25.3%	32.2%	33.5%	9.0%
3	Би сурагчдад мэргэжил сонголтын зөвлөгөө өгөхдөө хүйсээс нь үл хамаарч зөвлөгөө өгдөг (Жишээ нь хүүхдийн хүйсийг нь биш зан байдал, ур чадварт нь тохирсон мэргэжил санал болгох гэх мэт).	23.0%	17.0%	35.5%	24.5%
4	Би сургуулийнхаа бодлого, үйл ажиллагаануудыг илүү жендэрийн мэдрэмжтэй болгох тал дээр санал санаачилга гаргаж байсан.	34.3%	33.6%	26.3%	5.8%
5	Би хичээлийн үеэр эрэгтэй, эмэгтэй сурагчдын идэвх оролцоог тэгш үнэлдэг.	10.3%	13.6%	31.5%	44.5%
6	Би сурагчдын дунд жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэрт суурилсан хүчирхийлэл (үе тэнгийн дээрэлхэлт, дарамт зэрэг) ажиглагдвал холбогдох талуудад мэдээлдэг.	13.5%	24.2%	39.7%	22.6%
7	Би бусад багш нартай жендэрийн тэгш байдал, жендэрийн мэдрэмжтэй сургалтын арга барилын талаар ярилцаж, хэлэлцдэг.	24.1%	31.3%	33.5%	11.2%
8	Би хичээлийн үеэр жендэрийн мэдрэмжгүй үг хэлэх, үйлдэл илэрхийлэхгүй байхыг хичээдэг.	14.1%	16.5%	30.8%	38.8%

№	Бодомж	Огт үгүй	Ганц удаа	Хэд хэдэн удаа	Олон удаа
Сөрөг утга бүхий бодомжууд					
9	Би жендэрийн уламжлалт үүрэгт тохируулан охид, хөвгүүдэд ялгаатай даалгавар оногдуулдаг. (жишээ: охидыг цэвэрлэгээний ажилд, хөвгүүдийг үргэлж техникийн ажилд томилох гэх мэт).	43.3%	24.9%	25.4%	6.3%
10	Би хичээлийн болон бусад үеэр “эмэгтэй хүний үс нь урт ухаан нь богино, эр муу ч эмийн дээр, эр хүнд итгэснээс эрхий хуруундаа итгэ” зэрэг хэлц үгсийг хэрэглэж байсан.	63.6%	17.3%	14.7%	4.4%
11	Хүүхдүүд уламжлалт жендэрийн үүрэгт тохирохгүй хобби, сонирхолтой байвал би дэмждэггүй (жишээ нь эрэгтэй хүүхэд нүүр будалтын сургалтад суух, эмэгтэй хүүхэд бөхийн дугуйланд явах гэх мэт).	50.6%	22.6%	20.0%	6.8%
12	Би хичээлийн болон бусад үеэр эрэгтэй сурагчдад “эр хүн шиг бай”, “битгий охин шиг загна”, “эр хүн ийм байх ёстой” зэрэг үгсийг хэлж байсан.	38.2%	30.9%	25.4%	5.5%
13	Би охидыг хөвгүүдээс илүү цэвэрч нямбай, хичээнгүй байхыг шаарддаг.	36.1%	24.8%	30.4%	8.6%
14	Би эрэгтэй, эмэгтэй хоёр хүүхэд адилхан сахилгагүйтэх тохиолдолд эрэгтэйг нь үл тоож, эмэгтэйд нь илүү ач холбогдол өгдөг (Жишээ нь эмэгтэй хүүхэд байж үсэрч, харайлаа гэх мэтээр).	51.7%	27.3%	16.7%	4.4%
15	Би сурагчдын ахуйн ариун цэврийн асуудал дээр эмэгтэй сурагчдад илүү өндөр шаардлага тавьдаг (Жишээ нь эмэгтэй хүүхэд эрэгтэй хүүхдээс илүү цэвэрч байх ёстой зэргээр).	43.2%	26.5%	24.3%	6.0%

Сургуулийн орчинд багш нарын үйлддэг дадлыг илүү нарийвчлан тодруулах зорилгоор ЕБС-ийн ахлах ангийн сурагчидтай ФБЯ зохион байгуулсан билээ. Сурагчдын өгсөн мэдээллээс харахад сүүлийн жилүүдэд багш нарын жендэрийн мэдрэмж нэмэгдэж буй ч эрэгтэй, эмэгтэй сурагчдад ялгаатай байдлаар хандах явдал түгээмэл хэвээр байна. Сурагчдын дурдсан тодорхой жишээнүүдийг доор бүлэглэн харуулав.

- Багш нар охидыг илүү нямбай, эмх цэгцтэй гэж үздэг тул энэ хүлээлт дээрээ үндэслэн тэдэнд анги танхим, сургуулийн орчны цэвэрлэгээ хийх, дотуур байрны гал тогооны ажилд туслах, шалгалтын материал засах зэрэг хичээлээс гадуур ажил үүргийг хуваарилдаг байна.
- Охидод тавих хүлээлт өндөр байхын хэрээр тэдний хүлээх хариуцлага нь өндөр байдаг. Тухайлбал, хөвгүүдийн хичээл таслах, дүн гуйх, хичээлээс хоцрох, дүрэмт хувцасны дүрэм зөрчих зэрэгт багш нар хүлцэнгүй ханддаг бол охидод илүү өндөр шаардлага тавьдаг байна. Энэ нь багш нарын хэлдэг “эмэгтэй юм байж хичээл хийсэнгүй, эрэгтэйгээс дор”, “эмэгтэй хүүхэд учир



онц сурах ёстой” зэрэг үгсээр илэрдэг. Түүнчлэн, анги танхимын эрүүл ахуй, цэвэр цэмцгэр байдал нь охидоос хамаарна гэж үздэг тул охидыг илүү загнах, зэмлэх тохиолдлууд элбэг.

- Жендэрийн хэвшмэл ойлголтод тулгуурласан энэхүү хүлээлт нь сурагчдын сурлагын дүнд ч нөлөөлдөг байж болзошгүй байна. Тухайлбал, охидын мэдээлж буйгаар эрэгтэй сурагчдын бага хэмжээний хичээл зүтгэлийг багш нар өндрөөр үнэлдэг бол түүнээс илүү хичээл зүтгэл тогтмол гаргаж буй охидыг хэвийн зүйл мэтээр хүлээн авдаг байна. Тиймээс “сүүлийн үед хичээл зүтгэлтэй байгаа юм чинь”, “хуулаад ч болтугай хийгээд ирсэн юм чинь” зэрэг шалтгаанаар хөвгүүдийн дүнг өргөж тавих тохиолдлууд байдгийг онцолж байв.
- Эсрэгээрээ багш нар хөвгүүдэд уламжлалт эршүүд шинж байдлын дагуу хүлээлт тавих нь хэвээр байна. Тухайлбал багш нар хөвгүүдийг хээгүй, сахилгагүй гэсэн итгэл үнэмшилтэй, “эрэгтэйлэг” байх ёстой гэж үздэг тул “охин шиг хэрүүлч” зэргээр зэмлэх явдал байдаг талаар сурагчид мэдээлж байв. Мөн эрэгтэй, эмэгтэй хүүхдүүд муудалцахад охидын буруу байсан ч хөвгүүдэд гол бурууг тохох нь түгээмэл байдаг талаар багш, сурагчид санал нийлж байв.
- Энэхүү итгэл үнэмшлээс шалтгаалж хөвгүүд хичээл таслах, сахилгагүйтэх эрсдэлтэй гэж үзэн хичээлийн дундуур угаалгын өрөө оруулахыг зөвшөөрөхгүй байх явдал хэд хэдэн сурагчид тохиолдсон байна. Хөвгүүд

дагаад угаалгын өрөө орох болчихно гэсэн шалтгаанаар охидыг ч мөн угаалгын өрөө орохыг нь зөвшөөрдөггүй тул олон сурагчид хүндрэл үүсэж, 1-ээс олон цагаар угаалгын өрөө орж чадахгүй байх тохиолдол байдаг байна.

- Эрэгтэй хүүхдийн талаарх тогтсон ойлголтоос шалтгаалж зөвхөн багш нарын хандлага, дадал бус сургуулийн түвшинд жендэрийн мэдрэмжгүй үйл ажиллагаа явагддаг нь сурагчдын ярилцлагаас харагдаж байв. Тухайлбал, хоёр дотуур байртай нэгэн сургууль хуучин, тохилог бус, гаднаа нүхэн жорлонтой дотуур байрандаа хөвгүүдийг байрлуулж, эсрэгээрээ шинэ, тохилог байранд охидыг байрлуулж буйг охид мэдээлсэн. Түүнчлэн, хөдөлмөрийн хичээлийг эрэгтэй, эмэгтэйгээр нь ялгаж заадаг боловч зарим охид хөвгүүдэд ордог хичээлийг, зарим хөвгүүд охидод ордог хичээлийг судлахыг хүсдэгээ ярилцлагын үеэр дурдаж байлаа.

Дээрхээс харахад багш нарын уламжлалт ойлголт, хандлага нь зөвхөн үг хэллэг, агуулгын түвшинд төдийгүй өдөр тутмын дадал, шийдвэр гаргалт, сургуулийн дотоод зохион байгуулалт зэрэг олон түвшинд илэрч, эрэгтэй, эмэгтэй сурагчдад тавих хүлээлт, шаардлага нь сурагчдын эрх, оролцооны боломжид ялгаатай байдлаар нөлөөлж байна. Охидыг илүү цэвэрч, хариуцлагатай байх ёстой гэж үзэн нэмэлт үүрэг хүлээлгэх, илүү хатуу шаардлага тавихын зэрэгцээ хөвгүүдийг зөрүүд, сахилгагүй байх нь хэвийн мэт хүлээн зөвшөөрч, багш нар хүлцэнгүй ханддаг нь жендэрийн ялгавартай хандлагыг хэвшүүлж, сурагчдын тэгш суралцах орчинг алдагдуулж байна. Мөн хичээлийн үнэлгээ, сахилга бат, анги танхимын зохион байгуулалт, дотуур байр, угаалгын өрөө, хичээлийн хуваарь зэрэг сургуулийн орчны шийдвэр, бодлогод ч жендэрийн ялгаварлалт шингэсэн байх нь илт, энэ нь зөвхөн багшийн хандлага төдийгүй институцийн түвшний жендэрийн тэгш бус байдлын илрэл болж байна.

Багш нарын дадал тэдний тодорхой шинж байдлуудаас хамаарч ялгаатай байгаа эсэхийг One-way ANOVA буюу Вариацийн шинжилгээ хийж шалгахад хандлагын адилаар **нас, жендэр, жендэрийн тэгш байдлын талаарх сургалтад хамрагдаж байсан эсэхээс шалтгаалсан статистикийн хувьд ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсан**. Өөрөөр хэлбэл, багш нарын нас нэмэгдэх тусам болон жендэр, жендэрийн тэгш байдлын талаарх сургалтад хамрагдаж байсан бол илүү жендэр мэдрэмжтэй дадлыг хэвшүүлсэн байгаа харагдаж байна.

Хүснэгт 14. Багш нарын хандлагын дундаж оноо, шинж байдлаар (n=822)

Судалгаанд оролцогчдын шинж байдал	Хандлагын дундаж оноо	Ач холбогдолтой ялгаа бий эсэх
Нас		
21-29	2.82*	Тийм
30-39	2.83*	
40-49	2.84*	
50+	2.84*	

Судалгаанд оролцогчдын шинж байдал	Хандлагын дундаж оноо	Ач холбогдолтой ялгаа бий эсэх
Хүйс		
Эрэгтэй	2.8	Үгүй
Эмэгтэй	2.84	
Боловсролын түвшин		
Бакалавр болон дипломын	2.83	Үгүй
Магистр, доктор	2.84	
Багшилдаг сургуулийн байршил		
Улаанбаатар хот	2.84	Үгүй
Аймгийн төв	2.84	
Аймгийн төвөөс бусад сум	2.82	
Заадаг хичээлийн төрөл		
Бага ангийн багш	2.76	Үгүй
Математик	2.96	
Монгол хэл, уран зохиол	2.88	
Байгалийн ухаан (физик, хими, биологи, газар зүй)	2.86	
Түүх, нийгэм	2.97	
Гадаад хэл (англи, орос, бусад гадаад хэл)	2.88	
Зураг төсөл, зураг технологи, технологи	2.82	
Биеийн тамир	2.65	
Бусад (Мэдээлэл технологи, Эрүүл мэнд, Хөгжмийн боловсрол, Тусгай хэрэгцээт)	2.76	
Багшилж буй хугацаа (жилээр)		
0-3	2.85	Үгүй
4-9	2.82	
10-20	2.82	
21+	2.86	
Таны багш мэргэжлийн зэрэг		
Зэрэггүй	2.82	Үгүй
Заах арга зүйч	2.82	
Тэргүүлэх	2.85	
Зөвлөх	2.9	

Судалгаанд оролцогчдын шинж байдал	Хандлагын дундаж оноо	Ач холбогдолтой ялгаа бий эсэх
Жендэр, жендэрийн тэгш байдлын талаарх сургалтад хамрагдаж байсан эсэх		
Тийм	2.89*	Тийм
Үгүй	2.78*	

Тэмдэглэл: Ач холбогдолын түвшин; *** $p \leq 0.001$, ** $p \leq 0.01$, * $p \leq 0.05$; дээд оноо=30, доод оноо=0

Харин хүйс, боловсролын түвшин, багшилдаг сургуулийн байршил, багш мэргэжлийн зэрэг, заадаг хичээлийн төрөл зэрэг бусад хүчин зүйлсээс хамаарч багш нарын хандлагад статистикийн ач холбогдол бүхий ялгаа байсангүй. Гэхдээ заадаг хичээлийн хувьд мөн л биеийн тамирын багш нарын дундаж оноо хамгийн бага байхад түүх, нийгмийн багш нарын оноо хамгийн өндөр байна.

Хэдий судалгааны зорилго, хамрах хүрээнд хамаарахгүй ч мэдээлэл цуглуулалтын явцад илэрсэн хүүхдийн эрхийн зөрчлийг тайлангийн энэ хэсэгт онцлохоор шийдлээ. Улсын төсвийн нэгэн ЕБС Facebook платформ дээр сургуулийн групп чат үүсгэн, өдөр бүр хичээлээс хоцорсон сурагчдын зургийг дарж, тус чатанд оруулдаг байна. Сургуулийн ажилтнууд энэ аргыг хичээлээс хоцрох явдлыг бууруулахад үр дүнтэй арга гэж үзэн зарим багш, ажилтнуудын эсэргүүцлийг үл тоон хэрэгжүүлсээр байгааг судалгаанд оролцсон сурагчид болон тэдний үзүүлсэн нотлох баримтаас харагдаж байв. **Энэ арга хэмжээ нь Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйл дэх тодорхой заалтуудыг илтэд зөрчсөн, хүүхдүүдийн эрхэм чанар, нэр төрийг үл ойшоосон, сурагчдын эрхэд ноцтой халдсан явдал тул холбогдох талууд яаралтай анхааралдаа авч, шаардлагатай хариу арга хэмжээг аван, энэ үйлдэл бусад сургуулиудад давтагдахгүй байх чиглэлээр ажиллах шаардлагатай байна.**

4.4. Багш нарын мэдлэг, хандлага, дадлын хамаарлын шинжилгээ

Судалгаанд хамрагдсан багш нарын жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг, хандлага, дадлын хоорондын хамаарлыг олон хүчин зүйлийн регрессийн шинжилгээгээр тодорхойлсон. Үүний хүрээнд нийт гурван регрессийн шинжилгээ хийж, хувьсагчдын хоорондын нөлөөллийг үнэлсэн болно.

Судалгааны мэдлэгийн оноо анх 0–30 онооны хооронд үнэлэгдэж байсан бол хандлага болон дадлын хувьсагчид 1–4 онооны Лайкертийн шкал дээр суурилсан байв. Харьцуулалтын явцад хувьсагчдын интервал ялгаа регрессийн шинжилгээнд нөлөөлөх эрсдэлтэй гэж үзсэн тул мэдлэгийн оноог (0–30) → (0–4) болгон шугаман хувиргалт хийсэн. Энэ хувиргалтаар мэдлэгийн хувьсагчийг хандлага, дадлын хувьсагчидтай интервалын хувьд ижил түвшинд нэгэн жигд болгож, регрессийн коэффицентуудыг харьцуулах, тайлбарлах боломжийг сайжруулсан болно.

Хүснэгт 15. Багш нарын мэдлэг, хандлага, дадлын уялдаа холбооны регрессийн үр дүн

№	Тайлбарлагдаж буй хувьсагч	Тайлбарлагч хувьсагч	R ²	Гол нөлөөлөл
1	Мэдлэг	Хандлага, дадал	0.138	Хандлага ($\beta=0.4066$) Дадал ($\beta=0.4603$)
2	Хандлага	Мэдлэг, дадал	0.336	Мэдлэг ($\beta=0.0647$) Дадал ($\beta=0.4597$)
3	Дадал	Мэдлэг, хандлага	0.347	Мэдлэг ($\beta=0.0900$) Хандлага ($\beta=0.5696$)

Эхний шинжилгээгээр багш нарын мэдлэгийн түвшинг хандлага, дадлын хувьсагчаар тайлбарлахад $R^2 = 0.138$ гарсан бөгөөд энэ нь мэдлэгийн хэлбэлзлийн 13.8%-ийг хандлага болон дадал нийлээд тайлбарлаж байгааг харуулж байна. Хандлага ($\beta=0.4066$) болон дадал ($\beta=0.4603$) хоёулаа мэдлэгт статистикийн хувьд ач холбогдолтой эерэг нөлөө үзүүлж байгаа ч мэдлэгийг тайлбарлах чадвар харьцангуй сул байна.

Хоёр дахь шинжилгээгээр багш нарын хандлагыг мэдлэг, дадлын хувьсагчаар тайлбарлахад $R^2 = 0.336$ гарч, хандлагын хэлбэлзлийн 33.6%-ийг тайлбарлаж байгааг илтгэв. Энэ шинжилгээнд дадал ($\beta=0.4597$) нь хамгийн хүчтэй эерэг нөлөөтэй хувьсагч байсан бөгөөд мэдлэг ($\beta=0.0647$) мөн эерэг, статистикийн хувьд ач холбогдолтой нөлөөтэй боловч нөлөөллийн хэмжээ харьцангуй бага байна.

Гурав дахь шинжилгээгээр багш нарын жендэрийн мэдрэмжтэй дадлыг хандлага болон мэдлэгийн хувьсагчаар тайлбарлахад $R^2 = 0.3467$ байсан бөгөөд энэ нь дадлын хэлбэлзлийн 34.7%-ийг хандлага, мэдлэг хоёр нийлээд тайлбарлаж буйг харуулсан. Дадалд хамгийн хүчтэй нөлөө үзүүлж буй хувьсагч нь хандлага ($\beta=0.5696$) байсан бол мэдлэг ($\beta=0.0900$) эерэг, харьцангуй бага нөлөөтэй байлаа.

Эдгээр үр дүнгээс харахад **багш нарын жендэрийн мэдрэмжтэй дадал болон хандлага хоорондоо илүү хүчтэй уялдаатай**, мөн **хандлага нь дадалд, дадал нь хандлагад илүү хүчтэй харилцан нөлөөлж буйг** харуулж байна. Харин **мэдлэг нь хандлага, дадалд эерэг нөлөөтэй боловч нөлөөллийн хэмжээ харьцангуй бага** байгаа нь анзаарагдаж байна. Өөрөөр хэлбэл зөвхөн мэдлэгийг нэмэгдүүлэхээс гадна багш нарын жендэрийн тэгш байдлын талаарх хандлага, дадалд зэрэг анхаарах шаардлагатайг илтгэж байна.

5. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаагаар ерөнхий боловсролын сургуулийн багш нарын жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг, хандлага, дадлын (КАР) өнөөгийн түвшнийг үнэлэх зорилготой байв. Арга зүйн хувьд тоон болон чанарын хосолсон аргыг ашигласан. ЕБС-ийн нийт 822 багшийн дунд асуумж судалгаа, нэмэлтээр багш болон ахлах ангийн сурагчидтай фокус бүлгийн ярилцлага (нийт 5 бүлэг) зохион байгуулж, тоон үр дүнг гүнзгийрүүлэн тайлбарлав. Багш нарын мэдлэгийг 15 асуулт бүхий тестээр үнэлж, хандлага болон дадлыг дөрвөн түвшний Лайкертийн шкалаар (1-4 оноо) дүгнэн, дүнг “сөрөг/саармаг/ээрэг” ангилалд хөрвүүлэн шинжилсэн.

Багш нарын жендэрийн хэвшмэл ойлголт, тэр дундаа жендэрийн өрөөсгөл хүлээлт, хэвшмэл ойлголт, үүнтэй холбоотой практик, үйлдлүүд нь маргинал бүлгийн суралцагчдын хувьд сургуулиа орхих, сурлагын амжилтад нөлөөлөх нөхцөл бүрдүүлж байна. Сургуультай холбоотой хүчирхийлэл (зарим тохиолдолд жендэрт суурилсан) бэлгийн болон сэтгэл санааны хүчирхийлэл, бие махбодын шийтгэл зэрэг нь хүүхэд, өсвөр үеийнхний хувьд аюултай, айдас дүүрэн сургалтын орчныг бүрдүүлсэн хэвээр байна.

Монгол улс холбогдох хуулиуддаа хүн бүр хүйсээс үл хамааран сурч боловсрох эрхтэйг зааж, салбарын болон салбар хоорондын жендэрийн эрх тэгш байдлын баталгааг тодорхойлж, боловсролын салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах суурь зохицуулалтуудыг тусгасан байгаа нь сайшаалтай.

Монгол улсын хувьд ерөнхий боловсролын нийт багш нарын дийлэнх нь эмэгтэй багш нар. Тухайлбал, 2023-2024 оны хичээлийн жилд ЕБС-д нийт 36,993 үндсэн багш ажилласны 6,652 буюу 18% нь эрэгтэй, 30,341 буюу 82% нь эмэгтэй байна. Багш нарын хүйсийн ялгаатай байдал болон жендэрийн хэвшмэл ойлголт, эрэгтэй, эмэгтэй сурагчдад тавьж буй ялгаатай хүлээлт нь нэгдээд сурагчдын амжилтын талаарх ойлголт болон сурлагын амжилтад нөлөөлөх боломжтой.

Багш нар “Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого (2017-2024)”-ын талаар маш хангалтгүй, Боловсролын тухай багц хуулийн хүрээнд цоо шинэ заалт болон орсон жендэрээс үүдэлтэй хэрэгцээ нь боловсрол эзэмшихтэй холбоотой ялгаатай хэрэгцээ болохыг дийлэнх багш нар мэдэхгүй хэвээр байна.

Багш нарын жендэрийн мэдлэгийн түвшин тэдний тодорхой шинж байдлаас

хамаарч ялгаатай байгаа эсэхийг шалгахад багшилж буй хугацаа, мэргэжлийн зэрэг, жендэрийн тэгш байдлын талаарх сургалтад хамрагдаж байсан эсэхээс шалтгаалсан статистикийн хувьд ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсан. Тодруулбал, багшилж буй хугацаа, багш мэргэжлийн зэрэг нь нэмэгдэх тусам багш нарын жендэрийн тэгш байдлын талаарх мэдлэг өндөр болж байна. Сонирхолтой нь 50-аас дээш насны, мөн 20-оос дээш жил ажилласан багш нар бусад буюу залуу багш нараас илүү мэдлэгтэй байна.

Жендэр, жендэрийн тэгш байдлын талаарх сургалтад хамрагдаж байсан багш нар хамрагдаж байгаагүй багш нараас өндөр мэдлэгтэй байгаа нь энэ төрлийн сургалтууд багш нарын мэдлэгийг нэмэгдүүлэхэд үр дүнтэй болох нь батлагдсан. Фокус бүлгийн ярилцлагад оролцсон дийлэнх сурагчид багш нарыг жендэрийн тэгш байдлын талаарх сургалтад идэвхтэй хамруулах, энэ талын мэдлэгийг нь дээшлүүлэх, сурагчдын ялгаатай байдлыг ойлгож, хүлээн зөвшөөрч, жендэрийн мэдрэмжтэй сургалтын арга зүйд суралцах зайлшгүй шаардлагатайг онцолсон байв.

Судалгаагаар боловсролын салбарын бодлого, хөтөлбөрт жендэрийн тэгш байдлыг чухалчлах хэрэгтэй эсэх, багш нарыг жендэрийн мэдрэмжтэй сургалтын арга зүй, дидактикийн талаар сургах хэрэгцээ шаардлагыг тодруулахад 74 орчим хувь нь тийм гэж хариулсан. Өөрөөр хэлбэл дийлэнх багш нар цаашид энэ чиглэлээр сурах, чадавхаа бэхжүүлэхэд нээлттэй хандлагатай байгаа нь сайшаалтай үр дүн юм.

Багш нарын дунд хийсэн фокус бүлгийн ярилцлагаар эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийн давуу болон сул талыг багш нар хэрхэн үзэж буйг тодруулахад дийлэнх багш нар **охидыг нягт нямбай, анхаарал төвлөрөх чадвар сайтай, нухацтай** зэргээр тодорхойлж байв. Харин **хөвгүүдийн давуу талыг сэтгэн бодох чадвар сайтай, хурдтай, сэргэлэн, алсыг харах чадвартай** зэргээр тодорхойлох нь түгээмэл байлаа. Эсрэгээрээ охидын сул талыг дүгнэхдээ **эмзэг, сэтгэл хөдлөл ихтэй, өөрийнхөөрөө** гэсэн бол хөвгүүдийг **анхаарал төвлөрөх чадвар сул, тууштай биш, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадвар сул, буруу зүйлд уруу татагдахдаа амархан** зэргээр тодорхойлж байв. Эндээс багш нарын дунд жендэрийн уламжлалт хандлага хэвээр хадгалагдаж буйг харж болох ба багш нар энэхүү тогтсон хандлага дээрээ үндэслэж хүүхдүүдэд ялгаатай хүлээлт тавьж, харилцах нь жендэрийн тэгш бус байдлыг улам нэмэх эрсдэлтэй юм.

Хэдий нас, ажилласан жил нэмэгдэх тусам багш нарын жендэрийн талаарх мэдлэг нэмэгдэж байсан ч хандлагын хувьд эсрэгээрээ залуу багш нар илүү эерэг хандлагатай байгаа нь судалгаанаас харагдаж байна. Мөн жендэр, жендэрийн тэгш байдлын талаарх сургалтад хамрагдаж байсан багш нар хамрагдаж байгаагүй багш нараас илүү эерэг хандлагатай байгаа нь мэдлэгийн үр дүнтэй ижил, энэ төрлийн сургалтын ач холбогдол өндөр болохыг баталж байна.

Багш нарын дадлыг тохиолдол бүрийн хувьд харвал жендэрийн мэдрэмжтэй дадал тодорхой хэмжээнд төлөвшсөн байна. Тухайлбал, нийт багш нарын 76.0% нь сурагчдын идэвх оролцоог тэгш үнэлэх, 69.6% нь хичээлийн явцад жендэрийн мэдрэмжгүй үг хэллэг хэрэглэхгүй байхыг хичээх, 64.7% нь ангийн даргыг сонгохдоо эрэгтэй, эмэгтэй хүүхдүүдийг ээлжлэн сонгох, 62.3% нь жендэрийн ялгаварлан



гадуурхалтыг мэдээлэх зэрэг үйлдлийг олон удаа эсвэл хэд хэдэн удаа хийдэг гэж хариулжээ. Гэхдээ багш нарын 30 орчим хувь нь эдгээр үйлдлүүдийг огт хийдэггүй эсвэл ганц удаа хийсэн гэж хариулсныг зайлшгүй анхаарах шаардлагатай. Мөн жендэрийн мэдрэмжгүй тохиолдлуудад хэрхэн хариу үзүүлснийг харвал багш нарын 80.9% нь жендэрийн хэвшмэл ойлголт бүхий хэлц үгс хэрэглэх, 79.0% нь эрэгтэй, эмэгтэй хоёр хүүхэд адилхан сахилгагүйтвэл ялгаатай хандах, 73.2% нь уламжлалт үүрэгт тохирохгүй сонирхлыг үл дэмжих үйлдлүүдийг хийдэггүй эсвэл цөөн удаа хийсэн гэж хариулсан бол эсрэгээрээ 20 орчим хувь эдгээр үйлдлүүдийг хэд хэдэн удаа эсвэл олон удаа үйлдсэн хэмээсэн байна. Жендэрийн мэдрэмжгүй үйлдэл, үг, хандлага 5 багш тутмын 1-д буйг анхаарах шаардлагатай.

Харамсалтай нь судалгааны үр дүнгээс харахад, багш нарын сургуулийн орчинд жендэрийн тэгш байдлыг бие даан дэмжих оролдлого хамгийн сул байна. Сурагчдын өгсөн мэдээллээс харахад сүүлийн жилүүдэд багш нарын жендэрийн мэдрэмж нэмэгдэж буй ч эрэгтэй, эмэгтэй сурагчдад ялгаатай байдлаар хандах явдал түгээмэл хэвээр. Багш нарын жендэрийн хэвшмэл ойлголт, хандлага нь зөвхөн үг хэллэг, агуулгын түвшинд төдийгүй өдөр тутмын дадал, шийдвэр гаргалт, сургуулийн дотоод зохион байгуулалт зэрэг олон түвшинд илэрч, эрэгтэй, эмэгтэй сурагчдад тавих хүлээлт, шаардлага нь сурагчдын эрх, оролцооны боломжид ялгаатай байдлаар нөлөөлсөн хэвээр байна.

Охидыг илүү цэвэрч, хариуцлагатай байх ёстой гэж үзэн нэмэлт үүрэг хүлээлгэх, илүү хатуу шаардлага тавихын зэрэгцээ хөвгүүдийг зөрүүд, сахилгагүй байх нь хэвийн мэт хүлээн зөвшөөрч, багш нар хүлцэнгүй ханддаг нь жендэрийн ялгавартай хандлагыг хэвшүүлж, сурагчдын тэгш суралцах орчинг алдагдуулж байна. Мөн хичээлийн үнэлгээ, сахилга бат, анги танхимын зохион байгуулалт, дотуур байр, угаалгын өрөө, хичээлийн хуваарь зэрэг сургуулийн орчны шийдвэр, бодлогод ч жендэрийн ялгаварлалт шингэсэн байх нь илт, энэ нь зөвхөн багшийн хандлага төдийгүй институцийн түвшний жендэрийн тэгш бус байдлын илрэл болж байна.

Багш нарын ажилласан жил нэмэгдэх тусам жендэр, жендэрийн тэгш байдлын талаарх сургалтад хамрагдаж байсан бол илүү жендэр мэдрэмжтэй дадлыг хэвшүүлсэн байгааг судалгааны үр баталлаа. Энэ нь тухайн багшийн туршлагажсан, эрх мэдэлжсэн байдлыг илтгэж байна. Багш нарын мэдлэг, хандлага, дадлын авсан дундаж оноог заадаг хичээлийн төрлөөр нь хараад үзвэл биеийн тамир, бага ангийн багш нар хамгийн муу, түүх, нийгэм, монгол хэл, уран зохиолын багш нар хамгийн өндөр байгаа нь сонирхол татаж байв.

Үр дүнгээс **харахад багш нарын жендэрийн мэдрэмжтэй дадал болон хандлага хоорондоо илүү хүчтэй уялдаатай, мөн хандлага нь дадалд, дадал нь хандлагад илүү хүчтэй харилцан нөлөөлж буйг** харуулж байна. Харин мэдлэг нь хандлага, дадалд эерэг нөлөөтэй боловч нөлөөллийн хэмжээ харьцангуй бага байгаа нь анзаарагдаж байна. Өөрөөр хэлбэл зөвхөн мэдлэгийг нэмэгдүүлэхээс гадна багш нарын жендэрийн тэгш байдлын талаарх хандлага, дадалд сургуулийн орчин, соёл, мэргэжлийн сургалт, багш бэлтгэж буй тогтолцооны түвшинд анхаарах анхаарах шаардлагатай.

6. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Боловсрол, сургуулийн орчин бол эрх мэдлийн тэгш бус димамик үйлчилдэг онцгой орчин. Энд багш-суралцагч, суралцагч-маргинал бүлгийн суралцагч, багш-маргинал бүлгийн суралцагч гэсэн эрх мэдлийн харилцаа бий болдог. Тиймээс эрх мэдлийн харилцааны димамикийг ойлгох, давуу байдлаа цэгнэх, эрх тэгш байдлыг бий болгох үүрэг бүхий гол оролцогч тал нь багш юм. Учир нь эцгийн эрхт ёс нь боловсролын тогтолцоонд хүчирхийллийн соёлыг хэвийн болгож, эрх мэдлийн тэгш бус димамикийг уламжлал болгон үргэлжүүлсээр байдаг.

Багш нарын жендэрийн ялгаварлан гадуурхалт, жендэрийн хувьд харалган байдал нь нийгэм дэх ялгаварлан гадуурхлыг бэхжүүлэх суурь болдог бөгөөд хүйсийн (эрэгтэй, эмэгтэй, транс зэрэг), жендэрийн (эрэгтэйлэг, эмэгтэйлэг зэрэг), байршлын хувьд, хөгжлийн бэрхшээл, бэлгийн чиг баримжаа, яс үндэс, нийгэм эдийн засгийн статусын хувьд ялгаатай байдлыг улам бэхжүүлж байдаг.

Тиймээс боловсролын салбарт жендэрийн тэгш байдлыг хангахын тулд багш бэлтгэх тогтолцоо, багшийн мэргэжлийн сургалтанд жендэрийн өрөөсгөл болон тогтсон хандлагыг таниулах, жендэрийн мэдрэмжтэй заах арга зүйд сургах, дадал болгоход чиглэгдэх ёстой. Үүнд, сургалтын хэрэглэгдэхүүнийг илүү хүртээмжтэй болгохын тулд дахин загварчлах, шинээр бүтээх, ажил мэргэжлийн өргөн сонголтын талаар жендэрийн хэвшмэл бус хандлагаар зөвлөгөө чиглүүлэг өгдөг байх, жендэрт суурилсан хүчирхийлэл, дарамт дээрэлхэлтийг үл тэвчих хандлагыг төлөвшүүлэх зэрэг орно. Мөн сургууль, дотуур байрны орчин (3 хүрээнд: материаллаг, нийгэм-сэтгэл зүйн, засаглал) бүх хүйсийн суралцагчдын хувьд ээлтэй, аюулгүй, тэгш хүртээмжтэй байх ёстой.

Багш бэлтгэх тогтолцоо, мэргэжлийн хөгжил, сургалт:

- **Жендэрийн өрөөсгөл болон тогтсон хандлага, хэвшмэл ойлголтыг халах:** Хүний эрх, эрхэм чанар, болон жендэртэй холбоотой өрөөсгөл хандлага, хэвшмэл ойлголтыг халах агуулгыг багш бэлтгэх хөтөлбөрт заавал судлах хичээлээр оруулах, багшийн мэргэжлийн сургалтын агуулгад тусгах,
- **Жендэрийн мэдрэмжтэй заах арга зүй:** Суралцагчдын жендэрийн ялгаатай хэрэгцээнд тохирсон тэгш оролцоо, тэгш боломжийг дэмжих заах арга зүйд багш нарыг тогтмол, давтан сургах, тэдний сайн туршлагуудыг харилцан суралцуулах,

- **Тэгш хамруулсан сургалтын хөтөлбөр:** Багш нар хичээлийнхээ нэр томьёо, жишээг ашиглах, жендэрийн олон янз байдлыг тусгасан сургалтын хэрэглэгдэхүүнийг суралцагчдын ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн сонгохыг дэмжих,
- **Жендэрийн хэм хэмжээний сорилтууд:** Анги танхимдаа жендэрийн уламжлалт үүрэг, хэвшмэл ойлголтыг сөрөх арга хэрэгсэл, мэдлэгээр багш нарыг хангах,
- **Эрэгтэй мэргэжлийн багш** нарыг бодлогоор бэлтгэх, тогтвортой, хангамж сайтай ажлын байраар хангахад орон нутгийн санаачилга өрнүүлэх,
- **Сургалтын хөтөлбөрийн уян хатан зохицуулалт:** Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний тодорхой хувьд жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр агуулга, жишээ баримт, дасгал, зураг дүрслэлийг оруулах боломжийг нээж, үүнд хяналт тавих үүргийг сургалтын менежерүүдэд бий болгох,
- **Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих** холбоо, бүтэц бий болгох,
- **Хамтын ажиллагааг бэхжүүлэх:** Ажлын байран дээрээ жендэрийн мэдлэг, ойлголт нэмэгдүүлэхэд чиглэсэн технологид суурилсан хувилбарт сургалтуудыг мэргэшсэн төрийн бус байгууллагуудын дэмжлэг, оролцоотой бий болгох,
- Жендэрийн мэдрэмжтэй багшлахуйг хөгжүүлэх практикийг турших, сайн туршлага бий болгох хамтын платформ үүсгэх,

Сургууль, дотуур байрны орчин:

- **Аюулгүй, тэгш хамруулсан орчин, орон зай:** Сургууль, дотуур байрны орчин хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтаас ангид байж, бүх суралцагчид аюулгүй, хүндлэл бүхий мэдрэмжтэй байх,
- **Төвийг сахисан жендэрийн бодлого:** Сургуулийн бодлого, хөтөлбөрүүд жендэрийн хэвшмэл ойлголтыг үгүй болгоход чиглэсэн жендэрийн төвийг сахисан дүн шинжилгээ хийж, тогтмол хянах,
- **Дарамт, дээрэлхэлтийг үл тэвчих соёл:** Жендэрт суурилсан дээрэлхэлт, дарамтыг үл тэвчих хандлагыг хэрэгжүүлж, ийм байдалтай тулгарч, хохирогч болсон суралцагчдад дэмжлэг үзүүлэх,
- **Тэгш хамруулсан хөтөлбөр ба сургалтын хэрэглэгдэхүүн:** Жендэрийн өрөөсгөл ойлголт, хандлагаас ангид сурах бичиг, суралцахуйн материалуудыг бэлтгэж, тогтмол хянаж, үнэлж, жендэрийн тэгш байдлыг дэмжиж байх,
- **Ажил мэргэжлийн зөвлөгөө:** Суралцагчид жендэрийн хэвшмэл ойлголтод хязгаарлагдахгүйгээр ажил, мэргэжлийн өргөн хүрээний сонголтуудын талаар мэдэхэд дэмжлэг үзүүлж, мэргэжил сонголтын зөвлөгөө өгөх,
- **Жендэрийн хэвшмэл ойлголтыг сөрөх:** Охид, хөвгүүдийн жендэрийн талаарх ойлголтыг сайжруулах, хэвшмэл ойлголт, өрөөсгөл хандлагыг өөрчлөх хичээлээс гадуурх үйл ажиллагааны хөтөлбөр, төсөлт ажил зохион

байгуулах,

- **Сургуулийн засаглалын орчин:** Сургуулийн холбогдох баримт бичгүүдэд хүчирхийлэл дарамтын үзэгдэл гарсан тохиолдолд хариу арга хэмжээ авах, урьдчилан сэргийлэх талаар тодорхой арга хэмжээг тусгах, үлгэрчилсэн зааврыг боловсруулах, таниулах, багш нарыг жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр үр дүнтэй сургуулийн бодлого боловсруулж, тогтмол сурталчлах, хэрэгжилтийг хангах,

Хяналт-шинжилгээ, үнэлгээ:

- **Тогтмол үнэлгээ:** Жендэрийн тэгш байдлыг хангах санаачилгын үр нөлөөг тогтмол үнэлэх, сайжруулах шаардлагатай чиглэлүүдийг тодорхойлох, хэрэгжилтэд хяналт тавих,
- **Мэдээлэл цуглуулах:** Бодлого, практикийг мэдээлэхийн тулд дээрэлхэх, ялгаварлан гадуурхах тохиолдол зэрэг жендэрийн тэгш эрх, жендэрт суурилсан хүчирхийлэлтэй холбоотой суралцагчдын туршлагын талаарх мэдээллийг цуглуулах,
- **Охид, хөвгүүдийн суралцахуйн ахиц дэвшлийг мөшгих:** Боловсролын удирдлагын мэдээллийн системийг сайжруулан эрт сургууль завсардахаас урьдчилан сэргийлэх, боловсролын шат түвшин хоорондын шилжилт, төгсөлтийг мөшгих,

Олон нийтийн оролцоо:

- **Эцэг эхийн оролцоо:** Боловсролын салбарт жендэрийн тэгш байдлыг хангахад эцэг эхчүүд болон орон нутгийн иргэд, олон нийтийг татан оролцуулах,
- **Хамтран ажиллах арга:** Бусад сургууль, төрийн бус байгууллага, мэргэжилтнүүдтэй хамтран жендэрийн тэгш байдлыг хангах чиглэлээрх сайн туршлага, нөөцийг хуваалцах, түгээх,
- **Хөвгүүдийн боловсрол:** хөвгүүдийн боловсролоос хөндийрч байгаа тогтолцооны болон хувь хүний хүчин зүйлүүдийг арилгахад чиглэсэн стратегиуд Боловсролын яамны жендэрийн стратегийн нэг хэсэг байхад анхаарах,

УИТМН
СУДАЛГААНЫ САН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Acar-Erdol, Tuba, Ali Bostancioglu, and Fatma Dilek Gözütok. "Gender Equality Perceptions of Preservice Teachers: Are They Ready to Teach It?" *Social Psychology of Education* 25, no. 4 (2022): 793–818. <https://doi.org/10.1007/s11218-022-09712-8>.
- Aikman, Sheila, and Elaine Unterhalter, eds. *Practising Gender Equality in Education: Programme Insights*. Oxfam, 2007.
- Chudgar, Amita, and Vyjayanthi Sankar. "The Relationship between Teacher Gender and Student Achievement: Evidence from Five Indian States." *Compare: A Journal of Comparative and International Education* 38, no. 5 (2008): 627–42. <https://doi.org/10.1080/03057920802351465>.
- Dee, Thomas S. "A Teacher like Me: Does Race, Ethnicity, or Gender Matter?" *The American Economic Review* 95, no. 2 (2005): 158–65. JSTOR.
- Du Monde, Médecins. "The KAP Survey Model (Knowledge, Attitudes, & Practices)." USAID: Washington, DC, USA, 2011.
- Gunderson, Elizabeth A., Gerardo Ramirez, Susan C. Levine, and Sian L. Beilock. "The Role of Parents and Teachers in the Development of Gender-Related Math Attitudes." *Sex Roles* 66, nos. 3–4 (2012): 153–66. <https://doi.org/10.1007/s11199-011-9996-2>.
- Kollmayer, Marlene, Marie-Therese Schultes, Marko Lüftenegger, Monika Finsterwald, Christiane Spiel, and Barbara Schober. "REFLECT – A Teacher Training Program to Promote Gender Equality in Schools." *Frontiers in Education* 5 (July 2020): 136. <https://doi.org/10.3389/educ.2020.00136>.
- Lee, Jieun, Dong-Eun Rhee, and Robert Rudolf. "Teacher Gender, Student Gender, and Primary School Achievement: Evidence from Ten Francophone African Countries." *The Journal of Development Studies* 55, no. 4 (2019): 661–79. <https://doi.org/10.1080/00220388.2018.1453604>.
- Liao, Xuewei, Thi Phuoc Lai Nguyen, and Nophea Sasaki. "Use of the Knowledge, Attitude, and Practice (KAP) Model to Examine Sustainable Agriculture in Thailand." *Regional Sustainability* 3, no. 1 (2022): 41–52. <https://doi.org/10.1016/j.regsus.2022.03.005>.
- Lindner, Jana, Elena Makarova, Deborah Bernhard, and Dorothee Brovelli. "Toward Gender Equality in Education—Teachers' Beliefs about Gender and Math." *Education Sciences* 12, no. 6 (2022): 373. <https://doi.org/10.3390/educsci12060373>.
- Nürnbergger, Miriam, Josef Nerb, Florian Schmitz, Johannes Keller, and Stefan Sütterlin.

- "Implicit Gender Stereotypes and Essentialist Beliefs Predict Preservice Teachers' Tracking Recommendations." *The Journal of Experimental Education* 84, no. 1 (2016): 152–74. <https://doi.org/10.1080/00220973.2015.1027807>.
- OECD. *PISA 2022 National Report: Mongolia*. OECD, 2022. [https://cdn.greensoft.mn/uploads/users/2760/files/PDF/MONGOLIA_Report_English_WEB%20\(1\).pdf](https://cdn.greensoft.mn/uploads/users/2760/files/PDF/MONGOLIA_Report_English_WEB%20(1).pdf).
- Pedrajas, Raquel P and Jalandoni, Nove D. "Promoting Gender Equality in the Classroom: Teachers' Challenges and Strategies." *Journal for Educators, Teachers and Trainers* 14, no. 3 (2023). <https://doi.org/10.47750/jett.2023.14.03.048>.
- Retelsdorf, Jan, Katja Schwartz, and Frank Asbrock. "'Michael Can't Read!' Teachers' Gender Stereotypes and Boys' Reading Self-Concept." *Journal of Educational Psychology (US)* 107, no. 1 (2015): 186–94. <https://doi.org/10.1037/a0037107>.
- Sahin, Abdurrahman, Hulusi Cokadar, and Muhammet Usak. "Context, Process and Change: The Status of Prospective Teachers' Perceptions of Teaching Process." *Essays in Education* 23, no. 1 (2008): 3.
- UN. "Human Development Reports: Mongolia." UNDP Web site. Human Development Reports. Accessed August 30, 2025. <https://hdr.undp.org/data-center/specific-country-data>.
- World Bank. *Mongolia Gender Assessment*. World Bank, 2024.
- World Bank Group. "Gender Analysis in Education Sector of Mongolia: A Focus on Boys Education." Text/HTML. World Bank. Accessed August 30, 2025. <https://documents.worldbank.org/en/publication/documents-reports/documentdetail/148861604473066031>.
- А.Солонго, М.Баяржаргал, М.Бүжинлхам, and Б.Энх-Учрал. *Боловсрол, Шинжлэх Ухааны Салбарын Жендэрийн Бодлого Стратеги (2017-2024 Он) Дунд Хугацааны Хэрэгжилтийн Үнэлгээ*. Улаанбаатар, 2023.
- БШУЯ and БСҮХ. *Сургууль Завсардаж Болзошгүй Хүүхдийг Илрүүлэх Судалгааны Тайлан*. Улаанбаатар, 2021.
- БШУЯ and ЮНЕСКО. *ТХЗ 4 Хэрэгжилтийн Дунд Хугацааны Тайлан*. Улаанбаатар, 2022.
- Г.Доржжанцан, Э.Энхболд, and М.Өүлэн. *Монголын Сургуульд Транс Сурагч Байх Нь. "Бүх нийт боловсролын төлөө" иргэний нийгмийн үндэсний эвсэл*, 2023.
- Д.Амартүвшин, Д.Ариунтогос, А.Буянжаргал, Б.Цэнд-Аюуш, and Ч.Наранцэцэг. *Сургуулийн Орчин Дахь Жендэрийн Хэвшмэл Ойлоглт Сурагчдын Мэргэжил Сонголтод Нөлөөлөх Байдал*. Улаанбаатар, 2023.
- НБХСХ. *Бага, Дунд Боловсролын Жендэрийн Дүн Шинжилгээ*. Швейцарийн Хөгжлийн Агентлаг, 2016.
- Т.Эмүжин. *Боловсролоос Хөндийрч Буй Хөвгүүд*. Улаанбаатар, 2024.
- У.Туяа, Х.Энхжаргал, and М.Итгэл. *"Хувьсаж Буй Боловсрол" Үндэсний Хэлэлцүүлэг*. БШУЯ & БСҮХ, 2022.

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Мэдлэгийн асуулт, асуултын оноо

№	Асуулт	Хариулт	Зөв хариулт	Асуултын оноо
1	Жендэр гэж юу вэ?	<p>a. Эрэгтэй, эмэгтэй хүмүүст байгалиас заяасан биологийн болон физиологийн ялгаатай шинж байдал</p> <p>b. Эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлага</p> <p>c. Улс орон, ялгаатай нийгмүүдэд эмэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэж, тэдний эрхийг нэмэгдүүлэх үйл явц</p> <p>d. Мэдэхгүй</p>	Зөв хариулт b. Эх сурвалж: Монгол улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль	1
2	Жендэрийн тэгш байдал гэж юу вэ?	<p>a. Эмэгтэй, эрэгтэй хүмүүс, охид, хөвгүүдийн тэгш эрх, тэгш боломж</p> <p>b. Эмэгтэйчүүдийн эрхийг эрэгтэйчүүдийн эрхээс дээгүүр тавих үзэл</p> <p>c. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс бүх зүйлээрээ ижил, ямар ч ялгаагүй гэж үзэх үзэл</p> <p>d. Мэдэхгүй</p>	Зөв хариулт a. Эх сурвалж: Hand-book-on-gender-main-streaming-for-gender-equality-results-en.pdf	1

<p>3 Жендэрийн хэвшмэл үзэл/ойлголт гэж юу вэ?</p>	<p>a. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс ижил тэгш боломжоор хангагдах ёстой гэсэн ойлголт b. Бүх жендэрийн хүмүүсийг эрх тэгш байлгахыг дэмжсэн соёлын хэм хэмжээ c. Хүний гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийн талаар хүйсийн шинжээр уламжлагдан тогтсон ялгаатай ойлголт, хандлага d. Мэдэхгүй</p>	<p>Зөв хариулт с. Эх сурвалж: Монгол улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль</p>	1
<p>4 Дараахаас жендэрийн үүргийг зөв илэрхийлж буй өгүүлбэрийг сонгоно уу.</p>	<p>a. Жендэрийн үүрэг нь тухайн нийгэм, олон нийт болон нийгмийн бусад бүлэг дотор сурч эзэмшсэн зан үйл b. Жендэрийн үүрэг нь эрэгтэй, эмэгтэй хүмүүст төрөлхөөс ялгаатай оноогдсон, өөрчлөх боломжгүй үүрэг, хариуцлага c. Жендэрийн үүрэг нь эрэгтэй, эмэгтэй хүмүүст хуулиар олгосон эрх, үүрэг d. Мэдэхгүй</p>	<p>Зөв хариулт а. Эх сурвалж: Жендэрийн үүрэг бол тухайн нийгэм, олон нийт болон нийгмийн бусад бүлэг дотор сурч эзэмшсэн зан үйл байдаг ба эмэгтэй эрэгтэй хүмүүсийн хувьд зөв зохистой хэмээн тооцогддог үйл ажиллагаа, ажил үүрэг, хариуцлагыг ялган тодорхойлж байдаг. jender.indd</p>	2
<p>5 Бэлгийн чиг баримжаатай холбоотой дараах өгүүлбэрүүдээс аль нь худал вэ?</p>	<p>a. Бэлгийн чиг баримжаа гэдэг нь хувь хүний хэн нэгэнд бие махбод, хайр дурлал, сэтгэл санаагаар татагдах үзэгдэл b. Хүний биологийн хүйс бэлгийн чиг баримжааг нь тодорхойлдог c. Бэлгийн чиг баримжаа нь хүний ур чадвар, ёс суртахууныг шийдвэрлэж, тодорхойлохгүй. d. Мэдэхгүй</p>	<p>Зөв хариулт b. Эх сурвалж:</p>	1
<p>6 Боловсролын ерөнхий хуульд “суралцагчийн жендэрээс үүдэлтэй хэрэгцээг боловсрол эзэмшихтэй холбоотой ялгаатай хэрэгцээнд хамруулж үздэггүй” гэж үнэн үү?</p>	<p>a. Үнэн b. Худал c. Мэдэхгүй</p>	<p>Зөв хариулт b. Эх сурвалж: Боловсролын ерөнхий хууль</p>	3

7	Дараах тохиолдлуудаас аль нь жендэрийн ялгаварлан гадуурхалтад тооцогдох вэ?	<ul style="list-style-type: none"> a. Аль нэг хүйсийн гишүүнчлэл бүхий олон нийтийн ба төрийн бус байгууллага байгуулах b. Эцэг, эхийн хөрөнгийг зөвхөн эрэгтэй хүүхэд нь өвлөн авах эрхтэй талаар хуульчлах c. Нэг хүйсийн хүмүүсийг хамруулсан урлаг, спортын уралдаан, тэмцээн зохион байгуулах d. Мэдэхгүй 	Зөв хариулт b. Эх сурвалж: Монгол улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль	1
8	Боловсролын ерөнхий хуульд зааснаар “суралцагч нь жендэрийн тэгш байдлыг хангасан орчин, нөхцөлд суралцах үндсэн эрхтэй” гэж үнэн үү?	<ul style="list-style-type: none"> a. Үнэн b. Худал c. Мэдэхгүй 	Зөв хариулт a. Эх сурвалж: Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага, Амьдрах ухааны сургалтын багц, 2020 wcms_754276.pdf	3
9	Монгол улсад жендэрийн эрх тэгш байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэхэд төр, олон нийтийн тэнцүү оролцоог хангах гол байгууллага аль нь вэ?	<ul style="list-style-type: none"> a. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам b. Боловсролын яам c. Жендэрийн үндэсний хороо d. Мэдэхгүй 	Зөв хариулт c. Эх сурвалж: Монгол улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль	2
10	Тогтвортой хөгжлийн 17 зорилгын хэд дэх зорилго нь “Жендэрийн тэгш байдлыг хангах” зорилго байдаг вэ?	<ul style="list-style-type: none"> a. 5 b. 9 c. 13 d. Мэдэхгүй 	Зөв хариулт a.	3
11	Монгол улсад боловсролын салбарт зориулсан жендэрийн талаар баримтлах бодлого байдаг уу?	<ul style="list-style-type: none"> a. Тийм b. Үгүй c. Мэдэхгүй 	Зөв хариулт a. Эх сурвалж: боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарт жендэрийн талаар баримтлах бодлого (2017-2024)	3
12	Таны бодлоор сургууль завсардсан болон сургуулийн гадна байгаа хүүхдүүдийн хүйсийн харьцаа хөвгүүд, охидын аль нь илүү их байна вэ?	<ul style="list-style-type: none"> a. Хөвгүүд b. Охид c. Мэдэхгүй 	Зөв хариулт a. Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо CONT-1 Сургуульд хамрагдаагүй хүүхдийн эзлэх хувь	2

13	Жендэрийн мэдрэмжтэй сургалтын хөтөлбөр гэж юуг хэлэх вэ?	<ul style="list-style-type: none"> a. Жендэрийн уламжлалт үүргийг дэмжсэн сургалтын хөтөлбөр b. Олон талт үзэл бодлыг тусгаж, жендэрийн хэвшмэл ойлголтыг бэхжүүлэхээс зайлсхийсэн сургалтын хөтөлбөр c. Зөвхөн хөвгүүд эсвэл охидод зориулан боловсруулсан тусгай сургалтын хөтөлбөр d. Мэдэхгүй 	Зөв хариулт b. Эх сурвалж:	2
14	“Сургуулийн өмнөх боловсролын байгууллага зэрэг байгууллагын ажил, үйлчилгээний онцлогоос хамаарч нэг хүйсийн хүнийг сонгох нь жендэрийн ялгаварлан гадуурхалт мөн” гэж үнэн үү?	<ul style="list-style-type: none"> a. Тийм b. Үгүй c. Мэдэхгүй 	Зөв хариулт b. Эх сурвалж: ЖЭТБтХ-ийн 6.5.6	2
15	Боловсролын ерөнхий хуульд зааснаар бүх түвшний боловсролын сургалтын хөтөлбөрт жендэрийн эрх тэгш байдлын агуулгыг тусгах нь зайлшгүй юу?	<ul style="list-style-type: none"> a. Тийм b. Үгүй c. Мэдэхгүй 	Зөв хариулт a. Эх сурвалж: Боловсролын ерөнхий хууль	3



“БҮХ НИЙТ БОЛОВСРОЛЫН ТӨЛӨӨ!” ИРГЭНИЙ НИЙГМИЙН ҮНДЭСНИЙ ЭВСЛИЙН ТУНХАГ

Боловсрол нь хүн бүрийн өдөр тутмын амьдралд, насан турш нөлөөлөх үндсэн эрх, хүний хөгжлийн түлхүүр бөгөөд иргэн бүрт чанартай боловсрол олгох нь төрийн хүлээх гол үүрэг хариуцлага гэдэгт итгэн;

Өнөөгийн тогтолцоонд боловсролыг явцуу тодорхойлдог, хүн бүрийн ялгаатай байдлыг харгалздаггүй, ялгаварлан гадуурхдаг, хангалттай санхүүжилт олгодоггүй зэргээс шалтгаалан бодлого төлөвлөх, хэрэгжүүлэх үйл явцад цогц хандлага дутагдаж; боловсролын тогтолцооны үр өгөөж нь хувь хүний хүсэл тэмүүлэл, нийгмийн эрэлт хэрэгцээнээс асар зөрүүтэй байсаар ирсний улмаас үнэ цэнэтэй амьдарч, амьдралын чанараа дээшлүүлэх боломж олгохгүй байгаад сэтгэл зовнин;

Энэ нь эрх мэдлийн шударга бус бүтцийг бий болгож, тэгш бус байдлыг хадгалж үлдэх арга зам болж байгааг эсэргүүцэн;

Боловсролын чанар, хүртээмж, хариуцлагатай байдлын төлөө хүчээ нэгтгэн ажиллаж, энэ үйл явцад хувь хүн, иргэний нийгмийн байгууллага, бүлгүүдийг өргөнөөр татан оролцуулж, өргөн суурьтай, зохион байгуулалттай, хүчтэй хөдөлгөөн бий болгохыг чухалчлан;

Энэ үйл явцад нийгмийн бүх бүлэг, ялангуяа эрх мэдлийн цөөнхийн оролцоог хангахыг онцлон;

Иргэд, бүлгүүдийн мэдлэг, чадварыг хөгжүүлж, тулгарсан асуудлаа гаргаж ирэх, шийдлийг шаардах, хариуцлага тооцох чадавхтай болоход нь дэмжлэг үзүүлэхийг эрмэлзэн;

Боловсролын тогтолцоог хүний мэдэх, бүтээх, хүний ёсоор хамтран амьдарч, нэр төртэйгээр оршиход суралцахуйц, хувь хүний потенциал, чадвар, чадавхыг нээж, эерэг зан үйл, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэгдсэн, хүмүүнлэг, ардчилсан, хүн бүрийн эрхийг хангасан, тэгш хүртээмжтэй болгон өөрчлөхийг эрхэмлэн;

Хүүхэд, эцэг эх, багш, орон нутгийн бүлгүүд болон үндэсний, хэлний, соёлын, бэлгийн цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд, орлого багатай иргэд зэрэг дуу хоолойгоо хүргэж, шийдвэр гаргахад оролцож чадахгүй байгаа бүлгүүдийг эрх мэдэлжүүлэх зорилгоор боловсролын тогтолцоо, бодлогод хяналт шинжилгээ, үнэлгээ хийх чадавхыг бүрдүүлэх, нөлөөлөх ур чадвараа дээшлүүлэх шаардлагыг ухамсарлан;

Хүний эрх, жендэрийн тэгш эрх, үл ялгаварлан гадуурхах, хүчирхийллээс ангид, хүлээцтэй байх, нээлттэй, ил тод, хариуцлагатай байх зарчмыг баримтлан;

Монгол улсад боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах, төсвийг хянах, хариуцлага шаардах, бодлогод нөлөөлөх үндэсний кампанит ажил зохион байгуулах зорилгоор эвсэн нэгдсэнээ тунхаглаж байна.

2010 оны 9 сарын 3

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

